# ЖИЛИЙН ТАЙЛАН 2018

# АГУУЛГА


ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ 4

1. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ 6
    - Эрхэм зорилго, үнэт зүйлс 7
    - Түүхэн товчоон 10

2. БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА 13
    - Уулын ажил 16
    - Хүний нөөц 19
    - Эдийн засгийн үзүүлэлт 26
    - Хариуцлагатай уул уурхайн түүхт 40 жил 31

3. КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ 35
    - Төлөөлөн удирдах зөвлөлийн мэдээлэл 36
    - Компанийн ТУЗ-ийн зардлын төсөв, ТУЗ-ийн гишүүдийн эзэмшиж буй хувьцааны мэдээлэл 40
    - ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны тайлан 41
    - Компанийн удирдлагын бүтэц, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтнууд 42
    - Эрсдэлийн удирдлага 47
    - “Компанийн засаглалын кодекс”-ын хэрэгжилт 48

4. ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ Компанийн нийгмийн хариуцлага 49
    - Байгаль орчин, нөхөн сэргээлт 50
    - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй 54
    - Орон нутагт 56
    - Мэдээллийн ил тод байдал 57

5. ҮНЭТ ЦААСТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ 58
    - Ханшийн статистик 59
    - Үнэт цаас гаргасан түүх 60
    - Хувьцаа эзэмшигчдийн бүтэц 61

6. САНХҮҮГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН 62






# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ





Багануурын уурхай үүсэн байгуулагдсан цагаасаа улсынхаа гал голомтыг манаж, дүүргийнхээ хөгжлийн түүчээ болон зүтгэж, 40 дэх жилдээ үйл ажиллагаагаа амжилттай явуулж байна.

Манай уурхай Монгол Улсын нүүрсний хэрэглээний 50%, төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний 60%, дүүрэг орон нутгийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 78-80%-ийг дангаараа үйлдвэрлэдэг.

Бид "Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани" болохыг эрхэм зорилгоо болгон, эх орныхоо цахилгаан, дулаан хангамжийн найдвартай эх үүсвэр байсаар ирсэн нь манай уурхайн хамт олны хөдөлмөр зүтгэлийн үр дүн билээ. Монгол Улсын Засгийн газар бидний олборлосон нүүрсний үнийг өөрийн өртгөөс нь доогуур тогтоон, хатуу барьсаар ирсэн нь зах зээлийн зарчимд нийцэхгүй арга хэмжээ боловч төр иргэддээ үзүүлж байгаа хөнгөлөлт чөлөөлөлт гэж ойлгож болох юм. Үүнээс улбаалан компани олон жилийн турш алдагдал хүлээсээр байгаа нь нийгмийн хариуцлагаа хэрэгжүүлж байгаагийн хамгийн тод жишээ гэж бид үздэг. Компани 2018 онд 2019-2023 онд мөрдөж ажиллах дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулж дууссан бөгөөд 2019 оноос хэрэгжүүлэн ажиллана.

2018 он бид нүүрс олборлолт, борлуулалтын төлөвлөгөөг 102.7%, хөрс хуулалтын төлөвлөгөөг 101%, уулын цулын төлөвлөгөөг 106.7%-ийн гүйцэтгэлтэй биелүүлж, 887.4 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллалаа.



Энэ онд шинэ техник эдийн засгийн үндэслэлд тусгагдсаны дагуу уурхайн үндсэн ахилтын хойноос урагш чиглэлд өрнүүлэх бэлтгэл ажлын хүрээнд гүний ус шүүрүүлэх 10 ш цооног, 3 км агаарын шугам, ус зайлуулах 2.7 км коллектор, нийт 1,891.2 сая төгрөгийн дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийгдсэн бол ТАМ-уудын их болон агрегат засварын ажил 24.7%-ийн гүйцэтгэлтэй хийгдсэн нь ирэх жилийн их болон агрегат засварын ажил нэмэгдэх, техникүүдийн найдварт ажиллагаанд ихээхэн сөрөг нөлөөлөхөөр байна.

"Эрдэнэс Монгол" ХХК, "Эрдэнэс таван толгой" ХК-уудаас нийт 19.9 тэрбум төгрөгийн богино хугацаатай, хөнгөлөлттэй зээл авч, нэн түрүүнд төлөх шаардлагатай хуримтлагдсан өр төлбөрүүдийг барагдуулсны дунд 2018-2019 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг тодорхой хэмжээнд ханган ажиллаж чадсан. 2018 оны 1-р сарын 1-нээс Эрчим хүчний зориулалтаар нийлүүлэх бүй 1 тонн нүүрсний үнийг 2,000.0 төгрөгөөр нэмэгдүүлж, 31,500 төгрөгөөр борлуулахаар төлөвлөсөн ч Эрчим хүчний зохицуулах хорооны шийдвэр 3-р сарын 1-нд гарч, үүний дүнд уурхай 2 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэх боломж алдсан.

Мөн олон жил үргэлжилж байгаа орд ашиглалтын тусгай зөвшөөрлийн маргаан 2017 онд анхан болон давж заалдах шатны хоёр шүүхээр орж, уурхайн талд шийдвэрлэгдээд байсан боловч 2018 оны 2-р сарын 7-нд хяналтын шатны шүүхээс тус хэргийг дахин анхан шатны шүүхэд буцаасан. Тус шийдвэрийн дагуу 2018 оны 11-р сарын 7-нд дахин анхан шатны шүүх хурал болж, уурхайн талд шийдвэрлэгдсэн боловч 2019 оны 2-р сарын 20-ны өдөр хуралдсан давж заалдах шатны шүүх "анхан шатны шүүх хурлын дүгнэлтийг хэтэрхий ерөнхий байна" гэж үзэн дахин анхан шатны шүүхэд шилжүүлэх шийдвэр гаргасан.

2018 онд Багануурын уурхай үүсч хөгжсөний түүхт 40 жилийн ой тохиож, ойн хүрээнд бүтээн байгуулалтын чиглэлээр дугуйн зам, хүндэтгэлийн тулгат багана, хүндэтгэлийн хаалга, "Гэрэл" уран сайхны кино, "Бүтээн байгуулалт хөгжлийн нүүдэл" ном гаргасан бол спорт урлагийн чиглэлээр "Ширээний теннис"-ний ахмадын улсын аварга, "Гар бөмбөг"-ийн УАШ тэмцээн, "Үндэсний сурын харваа"-ны багийн аварга шалгаруулах тэмцээнүүд зохион байгуулсан. Үүнээс гадна ажилчнуудын дунд нарийн мэргэжлийн уралдаан, өндөр бүтээлийн уралдаанууд зохион байгуулаа.

2019 онд уурхайн хувьд чухал бүтээн байгуулалтын жил тохиож байгаа ба компани өөрийн хөрөнгөөр 4 технологийн машин, нэг байгууламж шинээр барих, нэг дэд бүтцийн нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг хийхээр төлөвлөж байна.

Э.НОМИНЧУЛУУН

# КОМПАНИЙН ЕРӨНХИЙ **МЭДЭЭЛЭЛ**




## АЛСЫН ХАРАА

- Монгол Улсын нүүрсний салбарын чиг хандлагыг тодорхойлогч байна.

## ЭРХЭМ ЗОРИЛГО

- Тогтвортой хөгжлийг хангасан, мэдлэг инновацид суурилсан үндэсний тэргүүлэгч компани болно.

## ҮНЭТ ЗҮЙЛС

- ***Аюулгүй байдал***
  Бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг нэн тэргүүнд тавьдаг.

- ***Санаачлагч, бүтээлч, суралцагч***
  Бид мэргэжилдээ хүндэтгэлтэй хандан санаачилгатай байж, шинэ шийдэл, ажлын шинэ аргам замыг бүтээлчээр хөгжүүлж, мэргэжлийн өндөр түвшинд үйл ажиллагаа явуулахын тулд мэдлэг ур чадвараа байнга дээшлүүлдэг.

- ***Шударга үнэнч***
  Бид зөвийг хийж, шударга, ил тод байдаг. Өөртөө болон бусдад зарчимч байдлаар хандаж, шударга бус байдалтай үл эвлэрнэ.

- ***Хариуцлага***
  Бид үүрэг хариуцлагаа ухамсарлаж, хийж буй үйлдэл, хэлсэн үгэндээ эзэн болдог.

- ***Багийн ажиллагаа, хамтын хүч***
  Бид харилцан итгэлцэл, хүндлэл бий болгосноор хүн бүр багийн нэг хэсэг болж, үр дүнтэй хамтран ажилладаг.

# КОМПАНИЙН
## СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ (2019-2023)

Компанийн 2014-2018 оны стратегийн төлөвлөгөөний хугацаа дууссан, ирэх 5 жилийн зорилго, зорилтоо тодорхойлох хэрэгцээ шаардлага үүссэнээс 2017 онд хийсэн байгууллагын бизнесийн процесс, ре-инженерингийн шинжилгээнд үндэслэн стратеги төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагын зөвлөмж авч боловсруулсан.

Тус стратеги төлөвлөгөөг эцсийн байдлаар тооцон ТУЗ-д оруулаагүй байгаа бөгөөд СЭЗБХ-ийн зүгээс бүх тооцооллыг хийж дуусгасан. Төрөөс эрчим хүч, уул уурхайн талаар баримтлах бодлого, “Багануур” ХК-ийн толгой компани болох “Эрдэнэс Монгол” ХХК-ийн стратегийн хүрээнд компанийн алсын хараа, үнэт зүйл, эрхэм зорилго, хөгжлийн зорилго зорилтуудыг шинэчлэн боловсруулсан.

**ЭРХЭМ ЗОРИЛГО**

*Харилцан ойлголцол, хамтын ажиллагаанд тулгуурлаж, бүтээмжид чиглэсэн байнгын сайжруулалт хийдэг манлайлагч хамт олон байна.*

**АЛСЫН ХАРАА**

*Өндөр бүтээмж бүхий технологиор манлайлагч байгууллага байна.*

**ҮНЭТ ЗҮЙЛС**

1. *Нэгдсэн бодлого, харилцан ойлголцол*
2. *Санаачилгатай байдал ба манлайлал*
3. *Нотолгоонд тулгуурласан оновчтой шийдвэр*
4. *Байнгын сайжруулалт*
5. *Бүтээмжид чиглэсэн хамтын ажиллагаа*

# “БАГАНУУР” ХК-ИЙН
## СТРАТЕГИЙН ЭРХЭМ ЗОРИЛГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД

*ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 1: Найдвартай ажиллагааны хөгжлийн зорилго*

*ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 2: Байгууллагын гарцыг нэмэгдүүлэх хөгжлийн зорилго*

*ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 3: Бүтээмжийг дээшлүүлэх хөгжлийн зорилго*

*ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 4: Удирдлага, зохион байгуулалтын хөгжил*

*ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 5: Хүний нөөцийн хөгжлийн зорилго*

*ХӨГЖЛИЙН ЗОРИЛГО 6: Компанийн нийгмийн хариуцлагын хөгжлийн зорилго*



# КОМПАНИЙН СТРАТЕГИЙГ
## ТОДОРХОЙЛОН БОЛОВСРУУЛСАН БАРИМТ БИЧГҮҮД






# ХЭРЭГЖҮҮЛЭХ
## ТӨСЛҮҮД

**ХАЙРГАНЫ ҮЙЛДВЭРИЙН ТӨСӨЛ**



Хайрганы нөөцийг 2 удаагийн геологийн хайгуулаар нарийвчлан тогтоосон. Нөөц 2,98 сая.м3. “Багануур” ХК нь Уул уурхайн хүрээлэнтэй хамтран “Хуцаа” элс-хайрганы хольцын ордыг ашиглах ил уурхайн ТЭЗҮ-ийг 2014 онд боловсруулсан.

**Хөрөнгө оруулалт 1.5 тэрбум төгрөг**

**“УС ШҮҮРҮҮЛЭХ БАЙГУУЛАМЖИЙН ТЕХНИКИЙН ШИНЭЧЛЭЛ” ТӨСӨЛ**



Уурхайн ус шүүрүүлэх байгууламж нь уулын ажлын ахилт, тэсэлгээний аюултай зайд орсон. Төслөө эрх бүхий байгууллага болох “Барилга хөгжлийн төв”-өөр 2014 онд батлуулсан.

**Хөрөнгө оруулалт 6.2 тэрбум төгрөг**

**110/6 КВ-ЫН УУЛЫН СТАНЦЫГ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ УРЬДЧИЛСАН ТӨСӨЛ**



“Багануур” ХК цахилгаан хангамжийн Уул 110/6кВ-ын дэд станцыг уулын ажлын өрнөлттэй уялдан шилжүүлэх шаардлагатай болсон.

**Хөрөнгө оруулалт 5.5 тэрбум төгрөг**

**УТААГҮЙ ШАХМАЛ ТҮЛШНИЙ ҮЙЛДВЭР**



Багануурын уурхайн хүрэн нүүрсэнд дулааны боловсруулалт хийх замаар хагас коксжуулж, нүүрсэн дэх дэгдэмхий бодисын агууламжийг багасгаж утаагүй шахмал түлш үйлдвэрлэн, Улаанбаатар хот болон бусад хот суурин газрын гэр хорооллын айл өрхийн хэрэглээнд нийлүүлнэ.

**Жилд 100.0 мян/тн утаагүй түлш**

# ТҮҮХЭН ТОВЧООН

**1975.6.29**
Монгол Улсын Төлөвлөгөөний комисс, Монголын гадаадтай эдийн засгийн талаар харилцах улсын хороо жилд 6 сая тн нүүрс олборлох хүчин чадалтай **Багануурын нүүрсний уурхай байгуулах** ТЭЗҮ-ийн даалгаврыг баталж, **ГИПРОШАХТ институт** боловсруулахаар шийдвэрлэв.

**1977.7.20**
**Түр уурхай байгуулах** тухай БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн **тогтоол** гарав.

**1978.2**
Анхны айл нүүж ирэв. **Шинэ хот байгуулах** Зөвлөлтийн барилгачид Нүүрэнтэй хөндийд ирж 20 вагон сууц, 3 жижиг байшинд байрлан ажлаа эхлэв.

Хүчин чадал 300 мянган тонн

**1978.3.1**
Уурхай анхны тэсэлгээ хийж ЭО-4121 маркийн экскаватор, МАЗ-503А өөрөө буулгагч автомашин, СБР-125 өрмийн машин, Д-4920 бульдозероор нүүрсний давхаргын ам нээх ажлыг эхэлж байв.

**1978.9**

**1980**
ЗСБНХУ-ын Черенхова хотод экскаваторын машинч нарыг бэлтгэж байв.

**1982**
Хүчин чадал **1.0 сая тн**

**1984.11**
Хүчин чадал **2.0 сая тн**

**1989**
Хүчин чадал **4.0 сая тн**

*АНУ, Японы Засгийн газрын буцалтгүй тусламж, зээлээр уул тээврийн техникийг шинэчлэв. (1992-1996)*

**1991**
Монгол Улс нийтдээ **7 сая** тонн нүүрс олборлосны **55%** буюу **3,9 сая тонн** нүүрсийг **Багануурын уурхай** олборлосон байв.

**1992.1.25**
Багануурын бүтээн байгуулалтын ажил дууссаныг дүгнэж гарын үсэг зурж ээ. Энэ нь ил уурхайн төслийн хүчин чадлыг жилд 6 сая тонн хүргэх сүүлчийн байгууламж болох жилд 2 сая тонн нүүрс олборлох хүчин чадалтай Багануурын ил уурхайн бүтээн байгуулалтын 2-р ээлжийн барилга байгууламжийн хоёрдугаар **ашиглалтын цогцолборыг** хүлээн авах улсын комиссын акт юм.

**1995**
Төрийн эзэмшил **75%**

Хувийн эзэмшил **25%**

**1996**
3.0 сая тонн нүүрс олборлон борлуулж, 8.1 сая шоо метр хөрс хуулан 17.4 сая шоо метрийн уулын цулын ажил гүйцэтгэж, Монгол Улсын нийт нүүрсний 60% гаруйг дангаараа олборлож, төвийн бүсийн цахилгаан станцуудыг нүүрсээр хангаж, 14.4 тэрбум төгрөгийн борлуулалтын ашиг олж, 882.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллав.
**1997 онд 21.9 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй МУ-ын хувьцаат компаниудын хамгийн том** нь болсон билээ.

**1997**
Төслийн хүрээнд уурхайн хөрс хуулалтын төмөр замын системийг авто тээвэртэй **хөрс хуулалтын системд** шилжүүлэв.

*Японы Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр MON P4 , MON P5 төсөл (1997-2000)*
*"Монгол нүүрс төсөл" (1996-2000)*

**1998.3-6**
Монгол улсад **анх удаа нөхөн сэргээлт** хийв.

**1999**

**2000**
Тус бүр нь жилд 2 сая тонн нүүрс бутлан ачих хүчин чадал бүхий 2 иж бүрдэл Технологийн дамжлагыг **1999-2002** онд барьж ашиглалтад оруулав.

**2002**
Бүтээмжийн хөдөлгөөн, Бүтээмж нэмэгдүүлэх арга хэрэгсэл болох **"Ажлын байрны соёл 5С"**-ийг нэвтрүүлэв.

*2004-2011 онуудад Бүтээмжийн тэргүүн туршлагыг Монголын компаниудад түгээв.*

**2004.5.24**
Аливаах тасралтгүй байнга, алхам алхмаар сайжруулах **Кайзен саналын систем** нэвтрүүлэв.

**2005.1.1**
Азийн бүтээмжийн байгууллагын "ЗАГВАР КОМПАНИ"

Байгууллагын үндсэн бүтэцтэй зэрэгцээ бүтцээр Байгууллагын өөрчлөлтийн менежментийг хөтөлбөр хэрэгжүүлэх зорилго бүхий **ШИНЭЧЛЭЛ баг** байгуулан, нийт 135 ажилтныг хамруулан ажиллав.

**2006.2.8**
Багийн үйл ажиллагаар дэмжиж, ажилчнуудын асуудал шийдвэрлэх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор **Чанарын дугуйлан**, тэнцвэржүүлсэн үнэлгээний хүүдас нэвтрүүлж эхлэв.

**2008**
1030 ажилтны үндсэн орон тоотойгоор ажиллаж байв.

**2011**
*Дэлхийн банкны санхүүжилтээр Геологийн нэмэлт хайгуулын төсөл*

**2013**
**Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон** авав.

Төрийн мэдлийн **75%** **"Эрдэнэс МГЛ" ХХК-д шилжив.**

**3.8 сая тн** нүүрс олборлов.

**2014**
Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд компанийн эрхэм зорилго, үнэт зүйл болон хөгжлийн 7 зорилгыг тодорхойлж, 1025 ажил, 334 ажилбартайгаар тодорхойлов.

Төслийн удирдлага хөгжлийн хүрээлэнгийн багш нартай хамтран "Багануур" ХК-д шууд ба шууд бусаар нөлөөлөх макро, микро орчны шинжилгээ, стратегийн бэлэн байдлын болон менежментийн чадамжийн шинжилгээ, дотоод орчны судалгаа хийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, компанийн **2014-2018 оны стратеги**йг тодорхойлж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар батлуулав.

**2015**
Нүүрс ангилан ачих байгууламжийн өргөтгөл хийгдэв.
1978-2015 оны 2-р сарын 9-ний өдрийг хүртэл **100 сая тн** нүүрс олборлов.

**2016**
Уурхайн **урт хугацааны ТЭЗҮ**-ийг хүлээн авав.

**2017**
**"Бизнес процессын ре-инженеринг, түүнд нөлөөлөх удирдлагын орчны иж бүрэн шинжилгээний төсөл"** боловсруулав.
**"1100 САНАА, 1100 АЖИЛ"** зорилтот хөтөлбөр хэрэгжиж эхлэв.

**2018**
**2019-2023** оны Стратеги төлөвлөгөө боловсруулав.
"Багануур" ХК-ийн **засаглалын үнэлгээний зөвлөмж** тайлан боловсруулав.
**4.2 сая тн** нүүрс олборлов.
**Хариуцлагатай уул уурхайн түүхт 40 жилийн ойгоо** бүтээлчээр тэмдэглэв.

# ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

| | | | |
|---|---|---|---|
| 1978 | 1995 | 75% ЭМГЛ<br>21,06% МНК<br>3,94% жижиг | 1123 |
| БАЙГУУЛАГДСАН | ХУВЬЦААТ КОМПАНИ БОЛСОН | ХУВЬ ЭЗЭМШИЛ | ҮНДСЭН АЖИЛТАН |

| | | |
|---|---|---|
| 4 сая.тн | 812,0 сая.тн | 47%, 2ш БНХК<br>53%, 1ш Алтайн гянт ХХК |
| ХҮЧИН ЧАДАЛ | ОРДЫН НИЙТ НӨӨЦ | ОРДЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ |



2018 онд
62% "Багануур" ХК
28% Шивээ-овоо ХХК
10% Шарын гол ХХК

ЭРЧИМ ХҮЧНИЙ НҮҮРСНИЙ ХЭРЭГЛЭЭ



Тээвэртэй,Тээвэргүй хосолсон системээр

АШИГЛАЛТЫН ТЕХНОЛОГИ



# ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

| Захиргааны ажилтан | Туслах чиглэлийн ажилтан | Уурхайн үйлдвэрлэлийн үндсэн ажилтан | Хүйсийн харьцаа | Оролт гаралтын хувь |
|---|---|---|---|---|
| 82 | 112 | 929 | 86% 14% | 4,9% 4,4% |

**Насны ангилал**

| 18-35 нас | 35-45 нас | 46-60 нас |
|---|---|---|
| 33% | 30% | 37% |

**Боловсролын түвшин**

| Дээд | Тусгай дунд | Бүрэн дунд | Бүрэн бус дунд |
|---|---|---|---|
| 30% | 8% | 56% | 6% |

**Ажилласан жил**

| 0-10 жил | 11-20 жил | 21- с дээш |
|---|---|---|
| 49% | 25% | 26% |

# БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА



# УУЛЫН АЖИЛ

“Багануур” ХК нь ТУЗ болон АМГ-аар хянан баталгаажуулсан төлөвлөгөөний дагуу 2018 онд 4,150.0 мян.тн нүүрс гаргаж борлуулах, 19,030.0 мян.м³ хөрс хуулах төлөвлөгөөтэй ажиллалаа.

Гүйцэтгэлээр нүүрс гаргалт 102.7%, нүүрс борлуулалт 102.5%, хөрс хуулалт 101.1, нийт уулын цулын ажил 106.7% биелэв.

Сар бүр 300.0 мян.тн нүүрсний шилжих нөөцтэй байхаар зорилго тавин ажилласнаас гүйцэтгэлээр 2019 оны 1-р сард 445.6 мян.тн авахад бэлэн нүүрсний нөөцтэй шилжсэн.

“Багануур” ХК, 2008-2018 оны нүүрс олборлолт (сая.тн)




“Багануур” ХК, 2008-2018 оны нүүрс борлуулалт (сая.тн)




Станцуудад нийлүүлсэн нүүрсний чанар, % (хэрэглэгчдээр)




Станцуудад нийлүүлсэн нүүрсний чанар, % (жилээр)








2018 оны хийсэн ажлын хэмжээг 2017 оны ажилтай харьцуулахад хөрс тээвэрлэлт 1.9% буюу 255.8 м.м³-ээр илүү, нүүрс тээвэрлэлт 2.5% буюу 92.4 м.тн-оор илүү, уулын цулын хэмжээгээр 2% буюу 326.8 м.м³-ээр илүү ажил гүйцэтгэсэн.

Хөрс хуулалтын төлөвлөгөөний биелэлт 101.1%, үүнээс, авто тээвэртэй хөрс хуулалтын төлөвлөгөөний биелэлт 99.4%, тээвэргүй хөрс хуулалтын төлөвлөгөөний биелэлт 106.6% гүйцэтгэлтэй гарсан.

| Үзүүлэлт | Хэмжих нэгж | 2016 оны гүйцэтгэл | 2017 оны гүйцэтгэл | 2018 он | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
| Хөрс | мян.м3 | 19606.6 | 21054.9 | 19030.0 | 19231.2 | 101.1% | 201 |
| Тээвэргүй | мян.м3 | 5908.2 | 6818.1 | 4785.0 | 5098.5 | 106.6% | 313.5 |
| Тээвэртэй | мян.м3 | 13470.7 | 13923.8 | 14095.0 | 14015.7 | 99.4% | -79.3 |
| Нүүрс олборлолт | мян.тн | 3913.8 | 4019.4 | 4150.0 | 4260.2 | 102.7% | 110.2 |
| Нүүрс борлуулалт | мян.тн | 3908 | 4039.2 | 4150.0 | 4255.6 | 102.5% | 105.6 |
| Хөрс шидэлт | мян.м3 | 5425.6 | 5476.7 | 4385.0 | 6021.4 | 137.0% | 1636.4 |
| Инженерийн ажил | мян.м3 | 726.6 | 858.2 | 700.0 | 845.3 | 120.8% | 45.3 |
| Хөрс хуулалтын коэф | м3/тн | 4.9 | 5.24 | | | | 4.5 |
| Нүүрсний шилжих нөөц | мян.тн | 310.3 | 379.3 | | | | 445.6 |
| Уулын цул | мян.м3 | 31860.9 | 33644.6 | 30653.5 | 32701.8 | 106.7 | 2048.3 |

**Хөрс хуулалтын коэффицент**




**Өрөмдлөг тэсэлгээний ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл**

| Өрөмдлөг тэсэлгээний ажлын үзүүлэлтүүд | Хэмжих нэгж | 2018 | | |
|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
| Тэсэлсэн уулын цул | мян.м3 | 13,790.3 | 10,844.6 | 78.6% |
| Хөрс | мян.м3 | 13,604.5 | 10,688.4 | 78.6% |
| Нүүрс | мян.м3 | 185.8 | 156.2 | 84.1% |
| Нийт өрөмдлөг | мян. метр | 293.4 | 319.2 | 108.8% |
| Хөрсөнд өрөмдлөг | мян. метр | 288.8 | 315.0 | 109.1% |
| Нүүрсэнд өрөмдлөг | мян. метр | 4.6 | 4.2 | 90.2% |
| Эмульсийн тэсрэх бодис | тн | 246.4 | 99.9 | 40.6% |
| Энгийн тэсрэх бодис | тн | 5,537.9 | 4,652.0 | 84.0% |
| Тэсрэх бодисын хувийн зарцуулалт | м3/кг | 0.46 | 0.44 | 95.3% |

# УС ШҮҮРҮҮЛЭЛТ

Уурхай 76 ширхэг гүний цооног, 2 ширхэг зумфээр ус шүүрүүлэлт хийж, 5.5 сая м$^3$ ус зайлуулсан.

Уурхайн гүнзгийрэлт (метр)






# ТЕХНИКИЙН АШИГЛАЛТ

"Багануур" ХК 2018 онд дараах тоног төхөөрөмжүүдтэй ажиллалаа.

| Тоног төхөөрөмжийн ангилал | Тоног төхөөрөмжийн марк | Тоо ш | Ашиглах хугацаа, жил | Ажилласан дундаж жил |
|---|---|---|---|---|
| Алхагч экскаватор | ЭШ-20/90, 15/90, 10/70, 13/50 | 6 | 20 | 33 |
| Авто хөрсний экскаватор | ЭКГ-10, ЭКГ-8И, ЭКГ-4У | 7 | 15 | 26 |
| Нүүрсний экскаватор | ЭКГ-5А, гидро экс | 6 | 15 | 26 |
| Тэсэлгээний өрмийн машин | СБР-160, D50KS | 6 | 15 | 25 |
| Хөрсний автосамосвал | CAT-777D | 17 | 8 | 11 |
| Нүүрсний автосамосвал | KOMATSU HD-405, Yutong, белаз, Hitachi | 10 | 8 | 10 |
| Овоолгын бульдозер | D-375, D-155, D10T | 6 | 8 | 16 |
| Замын техникүүд | GD-16, Terex, CAT-824, howo | 6 | 8 | 13 |
| Технологи дамжлага | Технологи дамжлага-1,2 | 2 | 20 | 18 |
| Бусад | CAT-320, ТЭМ-2У, CAT-988, МОАЗ | 12 | 8 | 16 |
| Нийт техникийн тоо | | 80 | 12.5 | 18 |






- Техникийн эвдрэлийн цаг 49,287 байгаа нь өнгөрсөн оноос 17% буурсан үзүүлэлт юм.
- 2018 онд компанийн нийт тоног төхөөрөмжийн ТББК 0.72% байгаа нь 2017 оноос 7% өссөн, ТАК 0.68% буюу өмнөх оноос 5% өсчээ.
- Төлөвлөсөн механик сэлбэгийн зардал 1.4%, цахилгааны сэлбэгийн зардал 21.3% хэтэрсэн нь нийт сэлбэг материалын зардал 3.2% хэтрэхэд нөлөөлсөн байна.












| Зардлын нэр | Төлөвлөлт (сая төгрөг) | Гүйцэтгэл (сая төгрөг) | Зөрүү (сая өгрөг) | Хувь |
|---|---|---|---|---|
| Механик сэлбэг | 13,896.00 | 14,101.00 | -205.00 | 101.5 |
| Цахилгааны сэлбэг | 1,406.00 | 1,706 | -300.00 | 121.3 |
| Хөдөлгүүр генератор | 1,735.00 | 2,101 | -366.00 | 121.1 |
| Засварын багаж | 138 | 126 | 12.00 | 91.3 |
| БҮТЭЗ | 45.6 | 42.6 | 3.00 | 93.4 |
| Нийт | 17,220.60 | 18,363.10 | -1,142.50 | 106.6 |

# САЛБАРТАА ЭЗЛЭХ
## БАЙР СУУРЬ

Өсөн нэмэгдэж буй хэрэгцээг болон салбарын найдвартай ажиллагаар хангах зорилгоор Эрчим хүчний яамнаас ойрын хугацаанд дараах төслүүдийг хийхээр төлөвлөж байна. Үүнд: “ДЦС-3”-ын суурилагдсан хүчин чадлыг 250 МВт-аар, Дарханы дулааны цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг 35 МВт-аар, “ДЦС-2”-ын хүчин чадлыг 50 МВт-аар тус нэмэгдүүлэхээр холбогдох тогтоол шийдвэрүүд нь гарсан бол Багануурын ЦС-ын төсөл улс төр, нийгмийн байдлаас шалтгаалан тодорхойгүй хугацаагаар хойшлоод байна.

Монгол Улсын эрчим хүчний хэрэглээ жилд дунджаар 5% өсдөг. Үүний нөлөөгөөр Багануурын уурхайгаас авч байгаа станцуудын нүүрсний хэрэглээ жилд 50-55 мян.тн-оор нэмэгдэж байна. (2019 оны станцуудын борлуулалт 2018 оныхоос 81.5 мян.тн-оор нэмэгдсэн)

“Багануур” ХК Монгол Улсын эрчим хүчний нүүрсний хэрэгцээний 60%, төвийн бүсийн нүүрсний хэрэгцээний 62%-ийг дангаараа хангаж байна. 0-200 мм бутармагтай нүүрсийг вагон болон бусад жижиг авто тээврийн хэрэгслээр хэрэглэгчдэд нийлүүлдэг.

Багануурын нүүрс физик, химийн шинж чанараараа зөвхөн эрчим хүчний зориулалтаар ашиглагдах төдийгүй дахин боловсруулалт хийж шатдаг хий, түлш, шингэн ба шахмал түлш, бусад химийн үйлдвэрлэлийн түүхий эд болох бүрэн боломжтой нь судалгаагаар батлагдсан. 2018 онд Багануур, Шивээ-Овоо, Шарын голын уурхайнууд эрчим хүчний станцуудад нийт 5.66 сая тн нүүрс олборлон борлуулсны 61.6%-ийг Багануурын уурхай, 28.6%-ийг Шивээ-Овоогийн уурхай, 9.7%-ийг Шарын голын уурхайгаас олборлосон байна.

**Нүүрсний зах зээл дэх байр суурь, 2018 он**

| № | Нэр | Жилийн нийлүүлэлт, 2018 он | |
|---|---|---|---|
| | | /мян.тн/ | Хувь |
| 1 | ДЦС-4 ТӨХК | 1,790.1 | 50 |
| 2 | ДЦС-3 ТӨХК | 1,331.5 | 100 |
| 3 | ДЦС-2 ТӨХК | 240.5 | 100 |
| 4 | Дархан ДЦС ТӨХК | 106.5 | 30 |
| 5 | Эрдэнэт ДЦС ТӨХК | 24.4 | 10 |
| 6 | Амгалан ДС | 92.2 | 25 |

Станцуудын нүүрсний хэрэглээний эзлэмж (хувь)




| Нэр | Стандарт илчлэг, ккал | Нэг тонн нүүрсний үнэ, төг | Kхх | Ажилтны тоо | Нийт уулын ажлын хэмжээ, мян.м$^3$ |
|---|---|---|---|---|---|
| “БАГАНУУР” ХК | 3,360 | 31500 | 4.5 | 1123 | 33,644.6 |
| “ШИВЭЭ-ОВОО” ХК | 2,900 | 27060 | 4.2 | 540 | 11,024.5 |
| “ШАРЫН ГОЛ” ХХК | 3,900 | 38,500 | 5.4 | 468 | 5,362.5 |

**Дундаж илчлэг /гкал/**








# ХҮНИЙ НӨӨЦ

**ЭРҮҮЛ УУРХАЙЧИН**
Өв тэгш бие бялдрын хөгжилтэй
Эрүүл, зохистой хооллолттой
Амьдралын зөв дадал хэвшилтэй

**ЗӨВ ҮЗЭЛ ХАНДЛАГАТАЙ УУРХАЙЧИН**
Үнэт зүйлтэй
Нийгмийн зөв төлөвшилтэй




**БОЛОВСРОЛТОЙ УУРХАЙЧИН**
Ажил мэргэжлийн ур чадвартай, мэдлэгтэй мэргэшсэн уурхайчин
Нийгэм, эдийн засгийн боловсролтой
Иргэний боловсролтой

**ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХИТАЙ УУРХАЙЧИН**
Бүтээмжид суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоотой
Санхүүгийн төлөвлөлт, ур ашигтай зарцуулалттай

**БАГАНУУРЫН УУРХАЙЧНЫ ХӨГЖИЛ**

Компанийн хүний нөөцийн бодлого чиглэлийг “Эрүүл, боловсролтой, зөв үзэл хандлагатай, эдийн засгийн чадавхтай” уурхайчид байхаар тодорхойлон ажиллаж байна. 2018 онд компанийн хэмжээнд хүний нөөцийн тогтвор суурьшил сайн, шилжилт хөдөлгөөн бага, ажилтнуудын сэтгэл ханамж өндөр байна.

2018 онд үйлдвэрлэлийн төлөвлөгөө 4150.0 тн нүүрс олборлон борлуулахаар өмнөх оноос нэмэгдэн батлагдсан тул зарим хэсэг нэгжийн хувьд ачааллаас шалтгаалан, мөн компанид хэрэгжүүлж байгаа стандарт төсөл, хөтөлбөрүүд дээр хүн хүч нэмэх шаардлагатай байсан боловч орон тоог нэмэхгүйгээр зохион байгуулж, 1123 ажилтны үндсэн орон тоотой ажиллаж байна.




Уурхайн ололт амжилтын үндэс нь чадвартай, мэргэжлийн ур чадвар бүхий, шударга, бүтээмж өндөртэй ажилтнууд юм.

БОЛОВСРОЛЫН БАЙДЛААР ХАРЬЦУУЛБАЛ:

Нийт ажилтны 26% нь дээд, 63% нь бүрэн дунд, 10% нь тусгай дунд, 1% нь бүрэн бус дунд боловсролтой.




307 бакалавр, 52 магистр, 19 мэргэшсэн, 3 зөвлөхийн эрхтэй, 1 докторын зэрэгтэй ажилтан ажиллаж байна.



АЖИЛЛАСАН ЖИЛИЙН БАЙДЛААР ХАРЬЦУУЛБАЛ:

Нийт ажилтны 49% нь 0-10 жил, 25% нь 11-20 жил, 26% нь 21-ээс дээш жил ажилласан байгаа нь ур чадварын хувьд туршлагажсаныг илэрхийлж байна.




2017 онд 97% байсан хүний нөөцийн тогтворжилтын коэффициент 2018 онд 97% хэвээр байгаа нь тогтвор суурьшил сайн байгааг харуууллаа. Энэ өндөр үзүүлэлт нь дээр дурьдсан бахархал, амжилт, уламжлал, сургалттай шууд холбоотойгоос гадна ажилтнуудын цалин хөлс, тэдний нийгмийн асуудалд тавьдаг анхаарал халамжтай холбоотой.

### Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн

| № | Нэр | 2015 он | 2016 он | 2017 он | 2018 он |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ажилд шинээр орсон | 46 | 37 | 51 | 56 |
| 2 | Ажлаас халагдсан | 31 | 31 | 40 | 50 |
| 3 | Дотроо шилжин ажилласан | 80 | 61 | 58 | 58 |

- Нарийн мэргэжил шаардсан ажлын байранд орох, шилжих ажилтнуудын мэргэжлийн болон анхан шатны шалгалтууд авсан.
- Ээлжийн дарга, ээлжийн мастер, ээлжийн механик, цахилгааны инженер НБАХ-ийн мастер сонгон шалгаруулах шалгалт ярилцлага зохион байгуулсан.
- 2017 онд ажилд шинээр орсон 51 хүний 26 нь, 2018 онд шинээр орсон 56 хүний 33 нь уурхайчдын үр хүүхэд, ач зээ байгаа нь ҮЕ ДАМЖСАН УУРХАЙЧДЫГ БИЙ БОЛГОХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ БАЙЛГАХ БОДЛОГО хэрэгжиж байгаагийн үр дүн юм.



### Тэтгэвэрт гарсан хүний тоо, сүүлийн 6 жилээр

| № | Төрөл | Хүний тоо | Олгосон тэтгэмж |
|---|---|---|---|
| 1 | 2013 онд тэтгэвэрт гарсан | 10 | 209 420 502 |
| 2 | 2014 онд тэтгэвэрт гарсан | 34 | 774 302 546 |
| 3 | 2015 онд тэтгэвэрт гарсан | 13 | 291 123 740 |
| 4 | 2016 онд тэтгэвэрт гарсан | 9 | 190 643 200 |
| 5 | 2017 онд тэтгэвэрт гарсан | 14 | 356 227 897 |
| 6 | 2018 онд тэтгэвэрт гарсан | 28 | 804 164 500 |
| | Дүн | 108 | 2 625 882 385 |

### Буцалтгүй тэтгэмж

| № | Нэр | 2015 он | | 2016 он | | 2017 он | | 2018 он | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Буцалтгүй тэтгэмж | 88 | 61056000 | 75 | 75880000 | 87 | 79960000 | 84 | 84960000 |
| 2 | Рашаан сувилал | 118 | 28715000 | 132 | 33119280 | 146 | 37538000 | 112 | 29210800 |

### Сургалтын чиглэлүүд, хамрагдсан ажилтны тоо

| СУРГАЛТЫН ЧИГЛЭЛ | | | 2014 | 2015 | 2016 | 2017 | 2018 |
|---|---|---|---|---|---|---|---|
| ГАДНЫ БАЙГУУЛЛАГА-ТАЙ ХАМТАРСАН | Инженер техникийн ажилтнуудын мэргэжил дээшлүүлэх | | 18 | 9 | 6 | 12 | 10 |
| | Инженер техникийн мэргэжлийн ба бусад сургалт | | 85 | 102 | 105 | 130 | 116 |
| | Инженер техникийн ажилтан туршлага судлах | | 8 | 29 | 3 | 23 | 27 |
| | Ажилтан туршлага судлах | | 15 | 28 | 10 | 12 | 20 |
| | Ажилтан мэргэжил дээшлүүлэх | | 15 | 13 | 6 | 8 | 6 |
| | Ажилтнуудын хандлага ур чадвар дээшлүүлэх | | 80 | 42 | 168 | 195 | 150 |
| | Гадаад сургалт | | - | 2 | - | 3 | 2 |
| КОМПАНИЙН ДОТООД СУРГАЛТ | Дотоод сургалт | | 91 | 88 | 65 | 140 | 92 |
| | Инженер техникийн ажилтан бэлтгэх анхан шатны чиглүүлэх сургалт | | 4 | 3 | 2 | 20 | 2 |
| | Ажилтнуудын хөрвөн ажиллах чадварт сургаж мэргэшүүлэх | | 4 | 4 | 8 | 12 | 4 |
| | Хэсэг нэгжүүдийн дотоод сургалт | | 3718 | 3857 | 3731 | 3810 | 3893 |
| | Мэргэжлийн чиг баримжаа олгох | Шинээр орсон | 62 | 45 | 37 | 40 | 42 |
| | | Дотроо шилжсэн | 103 | 63 | 61 | 10 | 41 |
| **НИЙТ** | | | **4225** | **4386** | **4285** | **4365** | **4322** |
| ШАЛГАЛТ | Мэргэжлийн зэргийн | | 12 | 6 | 10 | 15 | 12 |
| | Атестатчилал /ИТА, Экскаватор, Өрмийн машинч, операторууд, засварчид/ | | 128 | 193 | 180 | 85 | 136 |
| | Давтан шалгалт | | 13 | 18 | 8 | 6 | 12 |
| | Допускийн шалгалт | | 383 | 443 | 435 | 441 | 465 |
| **НИЙТ** | | | **536** | **660** | **633** | **547** | **625** |

# 1100 САНАА
## 1100 АЖИЛ

"Багануур" ХК нь бизнесийн үйл ажиллагаагаа урт хугацаанд амжилттай, тогтвортой явуулахад Компанийн нийгмийн хариуцлага түлхүүр үзүүлэлт болно гэдгийг хүлээн зөвшөөрч, анх 2014 онд Германы Олон улсын Хамтын ажиллагааны нийгэмлэг, "Нормисур интернэшнл"-ын зөвлөх багтай хамтран нийгмийн хариуцлагын стратеги төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Ингэснээр Монгол Улсын төрийн өмчит компаниудаас анх удаа компанийн нийгмийн хариуцлагын стратегитэй компани болсон.

Тогтвортой хөгжилд чиглэсэн Нийгмийн хариуцлага гэдэг бол ажилтан бүрийн хөгжил эргээд компани, дүүрэг орон нутаг, нийгмийнхээ хөгжилд нөлөөлж, хүн бүр тэгш боломжоор хангагдсан нийгэмд тэгш эрх эдэлж, амьдралын чанартай амьдрахыг хэлэх бөгөөд үүний тулд "Багануур" ХК-ийн удирдлагаас ажилтан бүрийн хөгжилд анхаарч ажиллахыг хичээж байна.

Зөв үзэл хандлагатай, зөв бодол сэдэлтэй, зөв үйлдэлтэй, амьдралын зөв дадал хэвшилтэй уурхайчин төлөвшүүлэх, өндөр хөгжилтэй улс орнуудаас суралцаж, компанийнхаа хөгжилд цаашлаад дүүрэг орон нутгийн хөгжилд хувь нэмэрээ оруулах зорилгоор "1100 санаа, 1100 ажил" зорилтот хөтөлбөрийг 2017 оны 9-р сараас нийт ажилтны дунд хэрэгжүүлж эхэлсэн. 2018 онд сургалт, хөгжлийн аялалд 214 ажилтан хамрагдаад байна. Хөтөлбөрт хамрагдсан ажилтнууд сургалт, хөгжлийн аялалд явж ирээд ХАБЭА-н нөхцлийг хэрхэн сайжруулах талаар ажиглан судалж харж үзсэнээ хэсэг, бригад, хамт олондоо хуваалцаж, өөрсдөө манлайлан олон ажил санаачлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт нийт 433 ажилтан хамрагдах хүсэлтээ илэрхийлэн гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд өнөөдрийн байдлаар 280 ажилтан Япон улсад 7 хоногийн хугацаатай сургалт, аялалд хамрагдан, 13 ажилтан Солонгос улсад болсон "PyeongChang 2018" өвлийн олимпын наадам үзээд байна. Үүнд компаниас нийт 307.7 сая төгрөг зарцуулаад байна.





- Нүүрс бутлан ачих хэсгийн ТЭМ-ийн машинч Ш.Батгэрэл "Хаях техник" ашиглан өөрийн ажлын байрандаа 5S хэрэгжүүлсэн.





















- Технологийн автомашин засварын хэсгээс аялалд хамрагдсан ажилтнуудын санаачилгаар хамт олон өөрсдийн сар бүрийн хуримтлалын сангаасаа заал талбайгаа тохижуулж, гаднаа усан оргилуур, бяцхан цэцэрлэг бүхий амрах саравч хийсэн.

Эрчим хүчний нэгдсэн хэсгийн хамт олон усан оргилууртай сүүдрэвч барьж, ажилтнуудын автобусны зогсоол байгуулсан.







- Уулын 1-р хэсгийн ажилтнууд хэсгийн гаднах хаягийг хаягдал төмөр ашиглан гэрэлтүүлэгтэйгээр шинээр хийж, ЭШ 10/70 №35, ЭКГ-8И №2250, ЭКГ-5А №1851, №1426 зэрэг экскаваторын гаднах өнгө үзэмж болон кабиныг сайжруулж тохижуулсан.







# ЭРҮҮЛ УУРХАЙЧИН ХӨТӨЛБӨР

1. ӨВ ТЭГШ БИЕ БЯЛДАРТАЙ ЭРҮҮЛ УУРХАЙЧИН ТӨЛӨВШҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

- Уурхайчдын гэр бүл, хүүхдүүдийн дунд 7 төрлийн дугуйлан нээж, нийт 120 гаруй хүн хичээллэж байна.
- 10-р сарын 8-наас 11-р сарын 5 хүртэл 28 хоногийн хугацаанд “Жингээ хасч галбиржих, жин нэмж галбиржих” фитнесс тэмцээн зохион байгуулсан. Тэмцээнд 44 ажилтан хамрагдаж, жин хасах төрлийн тамирчид дунджаар 5-6 кг хасаж, жин нэмэх тамирчид 4-5 кг булчингийн масс авч чадсан байна.




2. ЭРҮҮЛ ЗОХИСТОЙ ХООЛЛОЛТТОЙ ЭРҮҮЛ УУРХАЙЧИН ТӨЛӨВШҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

- Хоолны газруудын тогооч ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор дүүрэг болон сувилалтай хамтран сургалтад 23 хүнийг хамруулсан.
- 2018 оны сүүлийн хагас жилээс өглөөний цайны цэсэд сүүтэй шар будаа, сүүтэй овьёос, чанасан өндөг зэргийг сонголтоор оруулсан.
- “Багануур сувилал” ХХК өөрийн эрхэм зорилгод нийцүүлэн, мөн “Эрүүл уурхайчин” хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан компанийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор зохистой хооллолтын чиглэлээр сургах, зөвлөх үйлчилгээ үзүүлдэг VEG сургалтын төвтэй 3 сарын хугацаатай гэрээ байгуулж хамтран ажиллав.
- 2018 оны 3-р сарын 30-нд “Багануур” ХК-ийн ажиллагсад 400 гаруй хүнд “Зохистой хооллолтын орчин үеийн үзэл баримтлал ба тавгийн зарчим” сэдвээр уурхайн хурлын танхимд мэдээлэл хийсэн.
- 2018 оны 4-р сарын 6-ны өдөр “Нийгмийн эрүүл мэндийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлсэн. Өдөрлөгт Багануур дүүргийн ЗДТГ-ын Нийгмийн хөгжлийн хэлтэс, Багануур дүүргийн Нийгмийн эрүүл мэндийн төв болон Улаанбаатар хотын Нийгмийн эрүүл мэндийн газрын удирдлага, мэргэжилтнүүд, нийслэлийн 7 дүүргийн нийгмийн эрүүл мэнд хариуцсан орлогч дарга, мэргэжилтнүүдээс бүрдсэн 40 гаруй хүний бүрэлдэхүүнтэй зочид оролцсон. Мөн Багануур дүүргийн ААНБ-ын Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн гишүүд, уурхайчид хамрагдсан байна. Өдөрлөгийн үеэр “Багануур сувилал” ХХК-иас үйл ажиллагаанууд зохион байгуулсан.








3. АМЬДРАЛЫН ЗӨВ ДАДАЛТАЙ ЭРҮҮЛ УУРХАЙЧИН ТӨЛӨВШҮҮЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД:

- Бүх хэсгийн ажилтнуудад “Зүрх судасны өвчнөөс сэргийлье”, мөн “Зохистой хооллолтын орчин үеийн үзэл баримтлал ба тавгийн зарчим” сэдэвт сургалт зохион байгуулсан.
- Артерийн даралт ихсэлтээс сэргийлэх, хянах талаар дотоод сургалтыг 9 хэсгийн 320 орчим ажилтанд хийсэн.
- “Бусдад цусаа бэлэглэе” аяныг Дүүргийн цусны төвтэй хамтран зохион байгуулж, артерийн даралт ихсэлттэй 25 хүнийг хамруулсан нь даралт ихсэхээс сэргийлсэн ажил болсон. Артерийн даралт ихсэх өвчний улмаас ажлаас буусан ажилтны тоо 7.4% буурсан.






2017 онд дүүргийн Наран хорооллоос уурхай хүртэл 4.5 километр урт ДУГУЙН ЗАМ тавьсан. 2018 онд тус дугуйн зам дунд амрах орчин, тоглоомын талбай хийж, хоёр хажуу талаар 350 гаруй улиас, 2500 гаруй хайлаас тарьж тохижуулан нэлтээ хийж БҮРЭН АШИГЛАЛТАД ОРУУЛЛАА.

# ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

| Үзүүлэлтүүд | 2017 он гүйцэтгэл | 2018 оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
| Нийт орлого | 127,194.6 | 136,943.9 | 141,553.3 | 103.4 | 4,609.3 |
| Нийт зардал | 126,681.7 | 135,904.9 | 140,567.3 | 103.4 | 4,662.4 |
| ТТӨ ашиг | 512.9 | 1,039.0 | 985.9 | 94.9 | -53.1 |
| Цэвэр ашиг | 461.6 | 935.1 | 887.4 | 94.9 | -47.8 |







**СУУРЬ ШАЛТГААН**

Багануурын уурхайн нүүрсний ордын геологийн тогтоц нь хэвгий уналтай үчраас олборлолт, борлуулалтын хэмжээг тогтмол нэг түвшинд байлгасан ч жил бүр 3-5 метрээр уурхай гүнзгийрч байдаг. Үүнээс шалтгаалж хөрс хуулалт, гүний усны шүүрүүлэлт, тээврийн зай нэмэгдэж, ашиглалтын зардлыг жил ирэх тутам өсгөдөг.

Мөн тоног төхөөрөмжийн хүүчралт, инфляци, гадаад вальютын ханшийн өсөлт зэргээс хамаарч нэгж бүтээгдэхүүний өртөг жил бүр өсөөр байна.

ЗАРДЛЫН ТӨСӨВ




1 тонн нүүрсний үнэ, өртөг (төгрөгөөр)




Нэгж өртөг төлөвлөсөн хэмжээнээс өсөхөд дизель түлшний зах зээлийн үнэ, гадаад вальютын ханшийн өсөлт ихээхэн нөлөө үзүүллээ.

Нэгж өртгийн бүтэц (төгрөгөөр)

| № | Процессууд | Өртөг | Хувь |
|---|---|---|---|
| 1 | Ус шүүрүүлэлт | 607.9 | 1.8 |
| 2 | Өрөмдлөг тэсэлгээ | 1,498.8 | 4.5 |
| 3 | Хөрс хуулалт | 17,207.2 | 52.2 |
| 4 | Нүүрс олборлолт | 3,932.6 | 11.9 |
| 5 | Нүүрс борлуулалт | 3,014.0 | 9.1 |
| 6 | Санхүү болон удирдлагын зардал *(татвар, зээлийн хүү, даатгал, удирдлагын зардал)* | 6,735.0 | 20.4 |
| | Нийт дүн | 32,995.5 | 100 |

**Стандарт илчлэгээс давж олсон ашиг, /сая.төг/**






2018 оны төсөвт төлөх төлбөр 30.5 тэрбум төгрөг байгаагаас 24.0 тэрбум төгрөг нь байгууллагаас, 6.5 тэрбум төгрөг нь ажилтан албан хаагчдаас төлөгдсөн байна.

Нийт төсөвт төлөх төлбөрийн 57.0% нь улсын төсөвт, 2.7% нь нийслэл, 40.3% нь дүүрэг орон нутагт төлөхөөр байна.







Төсөвт төлөх төлбөрийн үлдэгдэл 2018 оны эхэнд 16.7 тэрбум төгрөг байсан ба тус онд нийт 30.5 тэрбум төгрөгийн татвар, төлбөр ногдож, үүнээс 26.0 тэрбум төгрөгийг төлж, 21.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.











| | 2017 он | 2018 он |
|---|---|---|
| Дансны өглөг /БН/ | 43,789.6 | 37,832.9 |
| Цалингийн өглөг | 5,452.8 | 2,751.5 |
| ЭМНД-ийн шимтгэл | 3,372.4 | 1,868.2 |
| Татварын өглөг | 13,157.7 | 19,161.2 |
| Богино хугацаат зээл | 19,568.7 | 37,001.0 |
| -Арилжааны банк | 17,368.7 | 15,110.1 |
| -Овердрафт | 2,200.0 | 1,990.9 |
| -Толгой компани | - | 19,900.0 |
| Бусад өглөг | 616.0 | 2,704.1 |
| **Нийт дүн** | **85,957.2** | **101,318.9** |



# ХЭМНЭЛТ
## ИННОВАЦИЙН ТӨСӨЛ





Монгол Улсад ЭШ 10/70 экскаваторын шанагыг "Багануур" ХК-ийн алтан гартай дархчууд өнгөрсөн оны зургадугаар сард анх удаа дотоод нөөц бололцоондоо тулгуурлан өөрсдөө үйлдвэрлэсэн билээ.

Эхний шанагаа ОХУ-ын шанаганы дизайнаар хийсэн бол хоёр дахь шанагаа Америк шанаганы зураг схем ашиглан хийсэн. Шанаганы үндсэн хэсгүүдийг листээр хийж, дотор хэсгүүдийг элэгдэлд тэсвэртэй материалаар хуягласан байна.

"Багануур" ХК-ийн ЭШ-10/70 маркийн 4 экскаватор жилд дунджаар 7 сая 140 мянган метр куб уулын цулын ажил гүйцэтгэх төлөвлөгөөтэй тул энэ нормоор компани жилд 2 ширхэг шанага худалдан авах шаардлагатай болдог. Шанагыг дотооддоо өөрсдөө үйлдвэрлэснээр шанага худалдаж авах зардлыг 40%-аас дээш бууруулах боломжтой болж, тэр хэмжээгээр зардал хэмнэгдэх юм.



ШАНАГА ҮЙЛДВЭРЛЭХ ТӨСӨЛ

БОДИТ ХЭМНЭЛТ **189** САЯ ТӨГРӨГ









## ХОЁРДУГААР САР

- Монгол Улсын Их сургуультай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав
- "Алтан уурхай-Миний уурхай" ярилцлагын нэвтрүүлэгт оров

## ГУРАВДУГААР САР

- Өндөр бүтээлийн аяны I шатны шалгаруулалт явагдав
- Пёнчон-2018 "Эрүүл агаар эм" цасны баяр зохион байгуулав
- АНРИ БЕЛИНКИН-ий "Монголын нүүрсний салбарын ил товчоон" номыг хүлээн авав
- Багануур дүүргийн хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг ивээн тэтгэв




## ДӨРӨВДҮГЭЭР САР



- Нийгмийн эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулав
- Улсын аварга шалгаруулах "Багануурын цом-2018" байт харвааны тэмцээн болов
- "Уурхайчдын ая дуу" урлагийн их наадам зохиов
- Автын инженерүүдийн гурван үеийн уулзалт болов
- Улсын аварга шалгаруулах туялзуур сэлэмний тэмцээн зохион байгуулав
- "Алтан уурхай-Миний уурхай" нэвтрүүлэгт Уулын I, Засварын хэсгийн хамт олон оролцов

# ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТҮҮХТ 40 ЖИЛ

БАГАНУУР ХК
ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТҮҮХ
40 ЖИЛ

## ТАВДУГААР САР

- Өндөр бүтээлийн аяны II шатны шалгаруулалт явагдав
- Олон улсын гэр бүлийн өдрийг угтсан "Нэг гэр бүл-Нэг мод" мод тарих өдөрлөг зохион байгуулав
- "Талархлаа" хамтрагчийн өдөрлөг явуулав
- "Алтан уурхай-Миний уурхай" нэвтрүүлэгт Уулын II, Үйлчилгээний автомашины хэсгийн хамт олон оролцов
- Хүндэтгэлийн тулгат баганыг байрлуулав
- Улсын аварга шалгаруулах волейболын насанд хүрэгчдийн тэмцээнийг ивээн тэтгэж зохион байгуулав
- "Ням гарагт нэг сая" цэнгээнт нэвтрүүлэгт уурхайчин залуус оролцов
- Үе үеийн гүйцэтгэх удирдлагуудын уулзалт болов
- Уурхайчдын хүүхдийн баярын өдөрлөг зохион байгуулав
- Уурхайгаас Багануур дүүрэг хүртэлх 4 км урт дугуйн замыг нээв
- Нүүрс бутлан ачих хэсгийн 3 үеийн уулзалт болов
- Засвар, Холбоо, Эрчим хүчний хэсгүүдийн 3 үеийн уулзалт болов
- Ахмадын Улсын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнийг хамтран зохион байгуулав




## ЗУРГАДУГААР САР

- Уулын хэсгүүдийн 3 үеийн уулзалт болов
- "Явлаа, ирлээ" МҮОНТ-ийн ярилцлагын нэвтрүүлэгт 1100 САНАА, 1100 АЖИЛ хөтөлбөрөөр оролцов
- Захиргааны хэсгийн 3 үеийн уулзалт болов
- Автын хэсгүүдийн 3 үеийн уулзалт зохион байгуулав
- Багануур дүүргийн аварга шалгаруулах "Орон нутаг-2018" шатрын тэмцээн зохион байгуулав
- Хүндэтгэлийн хаалга босгов
- "Алтан уурхай-Миний уурхай" нэвтрүүлэгт Технологийн автомашины засварын хэсэг, Технологийн автомашин ашиглалтын хэсэг, Эрчим хүчний нэгдсэн хэсгийн хамт олон оролцов
- "Уурхайчдын нэг өдөр" хүүхдэд зориулсан зурагт ном гаргав
- The Mongolian Mining Journal сэтгүүлийн тусгай дугаар бэлтгэв



## ДОЛДУГААР САР

- Уурхайчид хурлын зааланд 3*6 метр хэмжээтэй LED дэлгэц хандивлав
- Өндөр бүтээлийн аяны хагас жилийн шалгаруулалт явуулав
- "Алтан уурхай-Миний уурхай" нэвтрүүлэгт Нүүрс бутлан ачих хэсгийн хамт олон оролцов
- 'Илч" хамтлагийн "БАЯРЛАЛАА" кино концерт бэлтгэв
- Илгээлтийн эздийн уулзалт зохион байгуулав
- 40 жилийн удирдахуйн ухааны "Хөгжлийн нүүдэл" номын нээлт болов
- Компанийн захиргааны гаднах автомашины зогсоолын өргөтгөлийн ажил дуусав
- Компанийн захиргааны байрны фасадны засвар хийв
- Улсын аварга шалгаруулах Үндэсний сурын багийн тэмцээнийг дэмжин зохион байгуулав



ХАРИУЦЛАГАТАЙ УУЛ УУРХАЙН ТҮҮХТ 40 ЖИЛ

## 40 ЖИЛИЙН ОЙ

Баярын хурал, хүндэтгэлийн концерт баяр наадмын үйл ажиллагаа зохион байгуулав



## НАЙМДУГААР САР

- Дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан хүлээн авав
- Экскаватор, технологийн автомашин хосолсон виртуаль симулятор хүлээн авав



## ЕСДҮГЭЭР САР

Уурхайчид дүрээ мөнхөлсөн "ГЭРЭЛ" УСК-ны нээлт болов

Өндөр бүтээлийн аяны IV шат эхлэв

Зүүн бүсийн математикийн олимпиадыг ивээн тэтгэв





Уурхайчдын баярын хурал болов

# КОМПАНИЙН **ЗАСАГЛАЛ**



# ТУЗ-ИЙН МЭДЭЭЛЭЛ

“Багануур” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн 05 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгосон. Мөн өдрийн 03 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны зардлын төсвийг 144.6 сая төгрөг байхаар тооцож, хавсралтаар баталсан. “Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн 12 гишүүнтэй байхаар тогтоосон ба хараат бус 4, жижиг хувьцаа эзэмшигчийн төлөөлөл 2, төрийн төлөөлөл 6 гишүүнээс тус тус бүрдэж байна.



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

З.МЭНДСАЙХАН
Эдийн засагч

**Ажлын туршлага**

- 2001-2003 онд “Мон хангай” ХХК-ийн хэлтсийн менежер, захирал
- 2003-2004 онд “Дөрвөн уул” ХК-ийн гүйцэтгэх захирал
- 2004-2013 “МЭЭГ” ХХК-ийн гүйцэтгэх захирал
- 2013-2015 онд “Магнай Тайрэрс Монголиа” ХХК
- 2015-2016 онд Сангийн яаманд газрын дарга
- 2016 оноос Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

П.ГАНХҮҮ
Эдийн засагч

**Ажлын туршлага**

- 1997-1999 онд Нийгэм, эдийн засгийн дээд сургуулийн эдийн засгийн онолын багш
- 1999-2001 онд “МУИС-ийн бүтэц, удирдлагын механизмыг боловсронгуй болгох нь” Европын холбооны ТАСИС-ын төслийн Стратегийн төлөвлөлтийн дотоодын зөвлөх
- 2002-2004 онд Дэд бүтцийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, эдийн засгийн газрын мэргэжилтэн
- 2004-2006 онд Түлш, эрчим хүчний яамны Эдийн засаг, мэдээлэл, хяналт шинжилгээний газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
- 2006-2007 онд Түлш эрчим хүчний яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга
- 2007-2009 онд Түлш эрчим хүчний яамны Санхүү, эдийн засгийн газрын ахлах мэргэжилтэн
- 2009-2012 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрчим хүчний газрын орлогч дарга
- 2016-2017 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Эрчим хүчний сайд
- 2018 оноос “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

С.ЭРДЭНЭБУЛГАН
Барилгын инженер

**Ажлын туршлага**

- 2006-2010 он БЗААлба, инженер
- 2010-2012 он ССХОБЗАлба, Хэлтсийн дарга, инженер
- 2012-2013 он БХТөв, Хэлтсийн дарга
- 2016- оноос “Эрдэнэс Монгол” ХХК, Тэргүүн дэд захирал



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Г.ГАНБОЛД
Санхүү, эдийн засагч

**Ажлын туршлага**

- 2000-2003 он ХААИС, Сургалтын албаны менежер, багш
- 2003-2005 он “Дархан интер” банк, Эрхлэгч
- 2005-2007 он “Чингис хаан” банк, Дархан дахь төлөөлөгч
- 2007-2016 он “Чингис хаан” банк, Салбарын захирал
- 2011-2016 он “Монгол Алтан тос” ХХК, Ерөнхий захирал
- 2016 оноос “Эрдэнэс Монгол” ХХК, Санхүүгийн удирдлага хариуцсан дэд захирал



### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Г.НАНДИНЖАРГАЛ
Эдийн засагч

**Ажлын туршлага**

- 2003-2010 онд Монгол банкны Мөнгөний бодлого судалгааны газарт эдийн засагч
- 2010-2013 онд Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хотын хөгжлийн бодлогын хэлтсийн дарга
- 2013 онд Нийслэлийн Эдийн засгийн хөгжлийн газрын орлогч дарга
- 2013-2014 онд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
- 2014-2015 онд Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамны Хүнсний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
- 2015-2016 онд "Эрдэнэс Монгол" ХХК-ийн дэд захирлын багт Төслийн захирал
- 2016 оны 9-р сараас Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга



### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

М.БАЯРМАГНАЙ
Эдийн засагч

**Ажлын туршлага**

- 1999-2003 онд Маркетингийн газар эдийн засагч, ахлах
- 2003-2005 он Судалгаа маркетингийн газар захирал
- 2005-2006 онд Лондон, Сэргээн босголт хөгжлийн банкинд дадлагажигч ажилтан
- 2006-2008 ЖДБГ, захирал
- 2008-2011 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  үйлдвэрийн яам, ЖДҮ хөгжүүлэх сангийн захирал
- 2011-2012 Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, газрын дарга
- 2016 оноос Эрчим хүчний яамны газрын дарга



### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Б.НАРАНЦЭЦЭГ
Эрх зүйч

**Ажлын туршлага**

- 2016 оны 5-р сараас Санхүүгийн тайлан баланс гаргах, түүнтэй холбоотой болон бизнесийн, менежментийн зөвлөгөө өгөх, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлтэй гадаадын хөрөнгө оруулалттай компанид  хуулийн зөвлөхөөр ажиллаж байгаа





### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН



Б.ОЧБАДРАХ
Эдийн засагч, эрх зүйч

**Ажлын туршлага**

- 1983-1984 онд Улсын төлөвлөгөөний комисст мэргэжилтэн
- 1984-1989 онд МАХН-ын Төв хороонд улс төрийн ажилтан
- 1992-1998 онд Засгийн газрын Өмч хувьчлалын комисст орлогч дарга
- 1996-1998 онд "Мон Тэнэр" ХХК-ийн гүйцэтгэх захирал
- 1998-2016 онд "Бөөний худалдаа" ХК-ийн ерөнхий захирал

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН



Б.ОСОРГАРАВ
Эдийн засагч

**Ажлын туршлага**

- 1969-1976 онд Говь-Алтай аймгийн "Алтайн хөгжил" сонины хэвлэх үйлдвэрт ахлах ня-бо, орлогч дарга, эдийн засагч
- 1976-1981 онд Говь-Алтай аймгийн НААҮУГ-т ерөнхий нягтлан бодогч
- 1984-1986 онд Улаанбаатар хотын ОСНААУГ-т орлогч нягтлан бодогч
- 1986-1987 онд Нийтийн ахуйн үйлчилгээний яаманд ахлах мэргэжилтэн
- 1987-1997 онд Улаанбаатар хотын ОСНААУГ-т хэлтсийн дарга, ерөнхий нягтлан
- 1997-1999 онд "Оргил аудит" ХХК-ийн ерөнхий захирал
- 1999 оноос "Улаанбаатар аудит корпораци" ХХК-д ерөнхий захирал

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН



Д.АЛТАНЦЭЦЭГ
Эдийн засагч

**Ажлын туршлага**

- 1977-1980 онд Савхин эдлэлийн үйлдвэрт тасгийн дарга
- 1986-1996 онд Нийслэлийн УЗЭ-д салбар хорооны дарга
- 1993-2005 онд "Золач" ХХК-ийн гүйцэтгэх захирал
- 2005-2006 онд Төрийн өмчийн хороонд мэргэжилтэн
- 2006 оноос "Золач" ХХК-д гүйцэтгэх захирал

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН



Ш.АЛТАНЧИМЭГ
Эдийн засагч

**Ажлын туршлага**

- 1995-2008 онд дүүргийн НДХ-т байцаагч
- 2008-2009 онд НДЕГ-т мэргэжилтэн
- 2010-2014 онд Сэнлиэз дунд сургуулийн гүйцэтгэх захирал
- 2014-2015 онд "Сартуу өртөө" ХХК-ийн гүйцэтгэх захирал
- 2015-2016 онд ШӨХТГ-т газрын дарга

# КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ, ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН ЭЗЭМШИЖ БУЙ ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

2017 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТУЗ-ийн 2018 оны төсвийг 144.6 төгрөгөөр төлөвлөснөөс 135.9 сая төгрөг зарцуулж, төлөвлөгөөт зардлыг 8.7 сая төгрөгөөр хэмнэсэн байна. 2019 онд ТУЗ-ийн зардлын төсвийг 125.6 сая төгрөг байхаар төлөвлөсөн нь 2018 оны ТУЗ-ийн зардлын гүйцэтгэлээс 10.4 сая төгрөгөөр багасган 2018 оны зардлын төлөвлөгөөнөөс 19.1 сая төгрөгөөр бууруулан төлөвлөсөн дүн юм.

“БАГАНУУР” ХК-ИЙН 2019 ОНЫ
ТУЗ-ИЙН ЗАРДЛЫН ТӨСӨВ (МЯН.ТӨГ)

| 2017 оны | 2018 оны | | Хувь | 2019 оны төлөв | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө | гүйцэтгэл | | сард | жилд | |
| 13.0 | 13.0 | 13.0 | 100.0 | 13.0 | 13.0 | Дарга-1, хараат бус гишүүн-4, энгийн гишүүн 7, ТУЗ-ийн нарийн бичиг-1 |
| 113,130.9 | 112,008.0 | 117,160.8 | 104.6 | 7,776.3 | 93,316.0 | ТУЗ-ын дарга 630.0 мян төгрөг, хараат бус гишүүн 1200.0 мян.төг, гишүүд 528.0-580.0 мянган төгрөг |
| 14,287.9 | 12,320.9 | 12,533.2 | 101.7 | 1,005.9 | 12,070.4 | НДШ, ЭМД-ийн шимтгэлийн зардал |
| - | 720.0 | - | - | 60.0 | 720.0 | ТУЗ-ын ээлжит болон ээлжит бус хурал, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурал, г.м |
| - | 1,500.0 | - | - | 125.0 | 1,500.0 | Компанийн засаглалын болон бусад сургалт |
| 5,547.2 | 5,547.2 | 4,978.9 | 89.8 | 452.5 | 5,430.0 | “Багануур” ХК дээр ирж хуралдах үеийн унааны түлш шатахуун (Хувь нийлүүлэгчдийн хурал, ТУЗ-ийн хурал) |
| 380.0 | 960.0 | - | - | 80.0 | 960.0 | |
| 320.0 | 720.0 | - | - | 60.0 | 720.0 | Сард 60.0 мянган төгрөг |
| 126.5 | 240.0 | - | - | 20.0 | 240.0 | Сард 20.0 мянган төгрөг |
| 357.3 | 180.0 | - | - | 15.0 | 180.0 | Принтерийн хор-2ш, бичгийн цаас-10кг |
| 47.0 | 7,020.0 | 1,013.8 | 14.4 | 585.0 | 7,020.0 | Хурлын дараах хоол цайны зардал |
| - | 1,365.0 | - | - | 113.8 | 1,365.0 | Байрлах байрны зардал |
| 2,096.1 | 3,000.0 | 230.0 | 7.7 | 250.0 | 3,000.0 | ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбогдон гарах бусад зардал |
| 135,912.90 | 144,621.10 | 135,916.70 | 94.0 | 10,463.45 | 125,561.40 | |



# ТУЗ БОЛОН ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

“Багануур” ХК Монгол Улсын нүүрсний хэрэглээний 50%, эрчим хүчний нүүрсний 60%-ийг дангаараа хангадаг эдийн засгийн чухал ач холбогдол бүхий аж ахуйн нэгж юм. “Багануур” ХК-ийн эзэмшлийн 75% нь төрийн мэдэлд байгаа ба компанийн менежмент, үйл ажиллагааны удирдлага Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний төлөөллийг бүрдүүлэх үүргийг “Эрдэнэс Монгол” ХХК-иас хангаж байна.

“Багануур” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хараат бус 4, жижиг хувьцаа эзэмшигчийн төлөөлөл 2, төрийн төлөөлөл болох 6 гишүүнээс бүрдсэн 12 гишүүнтэй.

ТУЗ нь компанийг стратегийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагыг хянах үүргийн хүрээнд “Багануур” ХК-ийн эрх бүхий албан тушаалтны мэдээллийг тогтмол сонсож, компанийн үйл ажиллагааны онцлог, шуурхай байдлыг хангах чиглэл баримтлан Компанийн тухай хууль, Компанийн дүрмийн хүрээнд компанийн сайн засаглалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх чиглэлд гол анхаарал хандуулж ажиллалаа.

Өнгөрсөн хугацаанд буюу 2018 оны байдлаар Төлөөлөн удирдах зөвлөл 9 удаа хуралдаж, нийт 18 тогтоол гаргасан ба энэ хугацаанд Аудитын хороонд хамаарах асуудлаар 3 удаа хуралдсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь “Багануур” ХК-ийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, уурхайн үйл ажиллагаар чанаржуулах, компанийн эдийн засаг, санхүүгийн байдлыг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд анхаарч ирлээ.

Уурхайчдын хөдөлмөр зүтгэл, гүйцэтгэх удирдлага, ТУЗ, толгой компанийн зөв менежментийн үр дүнд “Багануур” ХК-ийн үйл ажиллагаа сайжирч, 2018 онд нүүрс олборлолт 102.7%, борлуулалтын төлөвлөгөө 102.5%, хөрс хуулалтын төлөвлөгөө 101.1%, уулын цулын төлөвлөгөө 106.7%-ийн гүйцэтгэлтэй биелсэн байна.

Компанийн тухай хуулийн 81.1 дахь заалт, “Багануур” ХК-ийн дүрмийн 10.16-д “ТУЗ нь аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой. Хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь хараат бус гишүүн байна” гэж ТУЗ-ийн 2018 оны 6-р сарын 11-ний өдрийн 14 дугаар тогтоолоор хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн томилсон. Аудитын хороо нь 5 гишүүнтэйгээс хараат бус гишүүн 3, цалин урамшууллын 3 гишүүнтэйгээс хараат бус 2 гишүүн, нэр дэвшүүлэх хороо 5 гишүүнтэйгээс 2 хараат бус гишүүн томилогдсон байна. ТУЗ-өөс томилсон нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилохоор “Багануур” ХК-ийн дүрмийн 10.18-д заасан байх бөгөөд түүний үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 2.5-д зааж өгсөн байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2018 онд 18 удаа хуралдан зохих шийдвэрүүд гарган ажилласан байна.





# КОМПАНИЙН УДИРДЛАГЫН БҮТЭЦ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА БОЛОН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД

Компанийн бүтэц, зохион байгуулалтыг ТУЗ-ийн 2017 оны 22 тоот тогтоолоор батлсан "Бүтэц орон тооны хязгаар батлах тухай" тогтоол, Гүйцэтгэх захирлын 2018 оны Б/26 тоот тушаалаар тус тус баталж, 29 бүтцийн нэгжтэй буюу 7 хэлтэс, 3 алба, 9 хэсгийн нийт 1123 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

"Багануур илч" ХХК, "Багануур сувилал" ХХК гэсэн 100% хувьцаар нь эзэмшдэг охин компанитай. Гүйцэтгэх захиралд зөвлөх үүрэг бүхий нийт 12 захирлын зөвлөлийн гишүүд хуваагдан, тухайн 2 охин компанийн ТУЗ-д ажилладаг бөгөөд ТУЗ-ийн даргаар "Багануур" ХК-ийн Гүйцэтгэх захирал ажилладаг.






**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ**
Эрдэнэ овогтой НОМИНЧУЛУУН

**Боловсрол:**
- Шинжлэх ухаан, технологийн их сургуулийг уулын цахилгаан механик мэргэжлээр төгссөн
- Удирдахуйн ухааны магистр
- Техникийн ухааны магистр

**Ажлын туршлага:**
- 1991 оноос ажлын гараагаа эхэлж, 1998 оноос хэсгийн дарга, хэлтсийн даргаар ажиллаж байгаад 2016 оноос компанийн Гүйцэтгэх захирлаар томилогдсон.



**ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ**
Намсрайжав овогтой БАЗАРСҮРЭН

**Боловсрол:**
- ШУТИС-ийг уулын ашиглалтын технологич мэргэжлээр төгссөн
- Мэргэшсэн инженер

**Ажлын туршлага:**
- 1998-2005 онд "Багануур" ХК-ийн Тээвэртэй хөрсний хэсгийн мастер, Нүүрсний хэсгийн мастер
- 2005-2006 онд технологич инженер
- 2006-2011 онд Уулын 1-р хэсгийн инженер, дарга
- 2011-2012 онд Үйлдвэр технологийн хэлтсийн дарга
- 2012 оноос Үйлдвэр эрхэлсэн дэд захирал



**ХҮНИЙ ХӨГЖИЛ СУДАЛГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ**
Октябрь овогтой ТУЯА

**Боловсрол:**
- ШУТИС, уул уурхайн ашиглалтын инженер мэргэжлээр төгссөн
- СЭЗИС, компанийн засаглалаар мэргэшсэн бизнесийн удирдлагын магистр

**Ажлын туршлага:**
- 2002-2003 онд "Багануур" ХК-ийн ЗХНХ-т архив, бичиг хэргийн эрхлэгч
- 2003-2007 онд Гүйцэтгэх захирлын туслах
- 2007-2009 онд Судалгаа хөгжлийн хэлтэст мэргэжилтэн
- 2009-2013 онд "Багануур" ХК-ийн 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани "Багануур илч" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
- 2013-2017 онд "Багануур илч" ХХК-ийн менежер
- 2017 оноос "Багануур" ХК-ийн Хүний хөгжил судалгаа эрхэлсэн дэд захирал



### ТЕХНИКИЙН БОДЛОГО ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ
Пүрэвжав овогтой ЭРДЭНЭЦОГТ

**Боловсрол:**
- 1991 онд Дарханы Политехникийн сургуулийг,
  1995 онд ТИС-ийг цахилгаан механик мэргэжлээр төгссөн
- Техникийн ухааны магистр

**Ажлын туршлага:**
- 1991-1996 онд экскаваторын туслах машинч
- 1996-2001 онд засварын механик
- 2001-2006 онд Техникийн бодлогын хэлтэст УТТ-ийн механик
- 2006-2009 онд Засварын хэсгийн хүчилтөрөгч компрессорын станцын механик
- 2009 оноос 2017.02 сард ХАБЭАХэлтсийн хяналтын инженер
- 2017 оноос Техникийн бодлого эрхэлсэн дэд захирал



### САНХҮҮ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ
Дангаасүрэн овогтой ГАНЗОРИГ

**Боловсрол:**
- СЭЗДС-ийг эдийн засагч, санхүүч мэргэжлээр төгссөн
- Удирдахуйн магистр

**Ажлын туршлага:**
- 2000-2004 онд Зоос банкинд хянагч ня-бо
- 2004-2006 онд Зоос банкинд эдийн засагч
- 2006-2010 онд Худалдаа хөгжлийн банкинд харилцааны менежер
- 2011.01-2011.12 онд Голомт банкинд Ипотекийн хэлтсийн захирал,
- 2012-2017 онд Голомт банкинд Уул уурхайн захирал
- 2017 оноос "Багануур" ХК-д Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал



### ЗАХИРГАА ХҮНИЙ НӨӨЦ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Баасан овогтой БАТБОЛД

**Боловсрол:**
- ХААИС-ийг Хөдөө аж ахуйн менежер мэргэжлээр төгссөн
- Бизнесийн удирдлагын магистр

**Ажлын туршлага:**
- 2004-2007 онд "Сүү" ХХК-д хангамжийн менежер
- 2007-2008 онд "Багануур сувилал" ХХК-д ерөнхий менежер
- 2008–2012 онд "Багануур сувилал" ХХК-д гүйцэтгэх захирал
- 2012-2017 онд хувиараа бизнес эрхлэгч
- 2017 оноос "Багануур" ХК-ийн Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга



### ТЕХНОЛОГИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Чинчулуун овогтой НАРАНБАТ

**Боловсрол:**
- ШУТИС-ийг уул уурхайн ашиглалтын инженер мэргэжлээр төгссөн

**Ажлын туршлага:**
- 2001-2003 онд "Багануур" ХК-ийн Тээвэртэй хөрсний, нүүрсний хэсэгт туслах машинч
- 2003-2008 онд Уулын нэгдсэн хэсэгт мастер
- 2008-2010 онд Технологийн бодлогын хэлтэст өрөмдлөг, тэсэлгээний инженер
- 2010 оноос Уулын 1-р хэсгийн дарга
- 2017 оноос "Багануур" ХК-ийн Технологийн бодлогын хэлтсийн дарга







### ТЕХНИКИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Хүрэлбаатар овогтой ХАШБАТ

**Боловсрол:**
- Политехникийн дээд сургуулийг уулын цахилгаан механик мэргэжлээр төгссөн.
- Техникийн ухааны доктор
- Монгол Улсын зөвлөх инженер

**Ажлын туршлага:**
- 1988-1993 онд Багануурын нүүрсний уурхайн цахилгаан хангамжийн хэсэгт кабел туршилтын мастер, засварын инженер, хэсгийн инженер
- 1998-2000 онд Нэгдсэн засварын газрын дарга
- 2000-2007 онд Техникийн бодлогын хэлтсийн дарга
- 2007-2017 онд Засварын хэсгийн дарга
- 2017 оноос Техникийн бодлогын хэлтсийн дарга



### ХУДАЛДАА ХАНГАМЖ ХАРИУЦСАН ХЭЛТСИЙН ДАРГА
Сүх овогтой БАТХИШИГ

**Боловсрол:**
- Политехникийн дээд сургуулийг уулын цахилгаан механик мэргэжлээр
- Удирдлагын хөгжлийн институтыг удирдлагын аргазүйч, зохион байгуулагч менежер мэргэжлээр төгссөн
- Техникийн ухааны магистр
- Удирдахуйн ухааны магистр

**Ажлын туршлага:**
- 1988-1992 онд Багануурын нүүрсний уурхайд ээлжийн механик, өндөр хүчдэлийн инженер, цахилгаан хангамжийн хэсгийн ерөнхий инженер
- 1994-1996 онд "Эм-Си-Эс" ХХК-д менежер
- 1996-1997 онд "Монстар" ХХК-д дэд захирал
- 1997-2001 онд "Залуучууд зочид буудал" ХХК-ийн захирал
- 2001-2004 онд "MTI" ХХК-д ерөнхий менежер
- 2004-2012 онд "Таван толгой" ХХК-д захирал
- 2010-2011 Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн чийглэгийг бууруулах, конвейрийн систем нэвтрүүлэх төслийн удирдагч
- 2012.01-2012.11 онд "Эрдэнэс таван толгой" ХХК-д ханган нийлүүлэх газрын захирал
- 2012.11-2017.01 онд "Талст хайрхан" ХХК-д захирал
- 2017 оноос "Багануур" ХК-ийн Худалдаа хангамж хариуцсан хэлтсийн дарга



### САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Дорж овогтой БОЛД

**Боловсрол:**
- Үндэсний биеийн тамирын дээд сургуулийг биеийн тамирын багш, дасгалжуулагч
- Монгол бизнес дээд сургуулийг ня-бо мэргэшсэн бизнесийн удирдлага мэргэжлээр төгссөн
- Удирдахуйн ухааны магистр

**Ажлын туршлага:**
- 2001-2006 онд Багануур дүүргийн Татварын хэлтэст татварын улсын байцаагч
- 2006-2013 онд Багануур дүүргийн Татварын хэлтсийн дарга
- 2013-2015 онд ГЕГ-ын Бүрдүүлэлтийн дараах шалгалтын газарт гаалийн улсын байцаагч
- 2015-2017.01 онд Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт татвар бүрдүүлэлтийн албаны дарга
- 2017 оноос "Багануур" ХК-ийн Санхүү эдийн засгийн бодлогын хэлтсийн дарга



**ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА**
Аюурзана овогтой ЭНХБОЛД

**Боловсрол:**
- Политехникийн дээд сургуулийг автын инженер механик мэргэжлээр төгссөн

**Ажлын туршлага:**
- 1989-1990 онд Багануурын уурхайн туслах аж ахуйд засварчин
- 1990-1995 онд Туслах аж ахуйн механик
- 1995-1996 онд ТАМАХ-ийн белазын ээлжийн механик
- 1996-1998 онд УАМХ засварын механик, Тээвэртэй хөрсний хэсэгт автын инженер
- 1998-1999 онд ТАМЗХ-ийн агрегат засварын механик
- 1999-2001 онд ТАМЗХ- ийн инженер
- 2001-2013 онд ТАМЗХ-ийн дарга
- 2013 оноос Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга



**СУДАЛГАА ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА**
Цэнд-Аюуш овогтой ЭНХБАТ

**Боловсрол:**
- ОХУ-ын Екатеринбург хотын Уралын техникийн их сургуулийг цахилгаан-механик инженер мэргэжлээр төгссөн
- Мэргэшсэн инженер

**Ажлын туршлага:**
- 1995-2015 онд механик инженер
- 2015-2018 онуудад "Мон цахим" ХХК-ийн гүйцэтгэх захирал
- 2019 оны 3 сараас "Багануур" ХК-ийн Судалгаа хөгжлийн хэлтсийн дарга





**ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА**
Батлантуу овогтой НАРАНЧИМЭГ

**Боловсрол:**
- ТИС-ийг инженер-эдийн засагч мэргэжлээр 1993 онд төгссөн
- Удирдлагын академийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй 2011 онд төгссөн

**Ажлын туршлага:**
- 1982-1987 онд Эрдэнэт хот, Горняк соёлын ордонд тайзны гэрэлтүүлэгч
- 1993-1997 онд "Багануур" ХК-ийн Засварын хэсэгт ня-бо, эдийн засагч
- 1997-2006 онд төлөвлөгч эдийн засагч
- 2006-2011 онд бүтээмжийн мэргэжилтэн
- 2011-2013 онд бүтээмж судалгааны мэргэжилтэн
- 2013-2016 онд төсөл судалгааны мэргэжилтэн
- 2016 оноос ДХША-ны дарга



**ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ**
Пүрэвжав овогтой ЭРДЭНЭ

**Боловсрол:**
- СЭЗДС-ийг нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр төгссөн.
- Мэргэшсэн нягтлан бодогч

**Ажлын туршлага:**
- 1984-1985 онд "Савангийн үйлдвэр"-т нягтлан бодогч
- 1985-1988 онд Цэргийн алба хаасан
- 1988-2011 Өглөгийн нягтлан бодогч
- 2011-2012 СЭЗХ-ийн дарга
- 2013 оноос "Багануур" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч



# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компанийн хэсэг, хэлтэс, албадын нийт ажилтны оролцоотойгоор 131 процесс тус бүрт хамаарах 256 асуудал, 467 шалтгаан, 503 шийдэл, 334 үүсч болох эрсдэл тодорхойлсон. Хэдий ийм ч эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх тогтолцоог бодлогын бичиг баримтад тусгаж, түүний нийцлийн хяналт хийгдэхгүй байгаагаас тодорхойлсон эрсдэлийг бууруулах, удирдах үйл ажиллагаа хийгдээгүй буюу эрсдэлд суурилсан хяналтын тогтолцоонд бүрэн шилжээгүй байна. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн OHSAS18001–2007 стандарт нэвтрүүлэхдээ ажлын байрны эрсдэлийн үнэлгээг 294 ажлын байранд хийсэн бөгөөд 79 ажлын байр өндөр эрсдэлтэй, 215 ажлын байр дунд эрсдэлтэй гэж үнэлэгдсэн.

Эрсдлийг бууруулах арга хэмжээ авснаар өндөр эрсдэлтэй ажлын байрыг 4, дунд эрсдэлтэй буюу хяналт тогтоох ажлын байрыг 175, бага эрсдэлтэй ажлын байрыг 115 болгож бууруулах боломжуудыг тогтоосон. Үүний дагуу илэрсэн аюул эрсдэлийг үнэлж, түвшингээс нь хамааруулан тодорхой хяналт тавих, улмаар осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор "Аюул эрсдэлийг үнэлэх, хяналт тогтоох журам" боловсруулан мөрдөн ажиллаж байна.





САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ



СТРАТЕГИЙН ЭРСДЭЛ



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

# “КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКС”-ЫН ХЭРЭГЖИЛТ

2018 онд компанийн гүйцэтгэх удирдлагын санаачилгын дагуу засаглалд Олон улсын санхүүгийн корпорацийн Төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдэд зориулагдсан нээлттэй үнэлгээний аргачлалаар үнэлж, ЭЗХАХБ-ын 2015 оны Компанийн засаглалын зарчмууд, МУ-ын “Компанийн тухай хууль”, СЗХорооны 2014 оны “Компанийн засаглалын кодекс” болон холбогдох дүрэм журмын хүрээнд нийцлийн үнэлэлт, зөвлөмж гаргасан байна. Ахиц дэвшлийн хүснэгтээр компанийн засаглалын наад захын шаардлага хангагдсан түвшинд буюу 1,2-р түвшинд байна гэж зөвлөмж гаргасан байна.

“Багануур” ХК нь Хувьцаа эзэмшигчийн хурлыг хуулийн хугацаанд нь хуралдуулдаг, жижиг хувьцаа эзэмшигчдийн сонгогдох эрхийг кумулятив аргаар баталгаажуулсан, ТУЗ-ийн хувьд хуульд заасан хэмжээгээр хараат бус гишүүнийг бүрдүүлсэн, сайн засаглалд нийцүүлэн боловсруулсан дүрэм журмуудтай, компанийн ашгаас ажилтны хүртэх боломжийг сангуудаар бүрдүүлж, тодорхой хэмжээгээр ажилтнууд ашиг, үр дүнг хүртсэн зэрэг сайн жишээ байгаа боловч батлагдсан дүрэм, журмын хэрэгжилт хангалтгүй, тэдгээрийн хэрэгжилтэд нийцлийн хийгээд үр дүнгийн хяналт хийгдээгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа идэвхтэй биш, төлөвлөлт, хяналт, үнэлгээг үр дүнтэй хийдэггүй, хороодууд байгуулагдаж, дүрэм журмаа боловсруулсан боловч идэвхитэй үйл ажиллагаагүй, компанийн нээлттэй ил тод байдал зарим талаар хангалтгүй, хараат бус гишүүд хуульд заасан нэмэлт үүргийн дагуу ажиллаж байсан эсэх талаар тайлан тавьж байгаагүй болон цалин урамшуулал ялгаатай ч цалин урамшуулал ажлын үр дүн гүйцэтгэлтэй холбогддоггүй, тогтмол байдлаар бусад гишүүнээс тодорхой хувиар өндөр, компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь эрх бүхий албан тушаалтан байдаг ч Иргэний хуулиар иргэний үүргийн гэрээ байгуулсан, компанид эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж, эрсдэл бууруулах талаар ажиллаж байсан тайлан мэдээлэл байхгүй, эрсдэлийн тогтолцооны үндсэн нэгж болсон Дотоод хяналтын нэгжийн бие даасан хараат байдлыг хангаагүй, дотоодын хяналтуудыг хэрэгжүүлдэг боловч үр дүнг авч хэлэлцдэггүй зэргийг баримтаар баталгаажуулан зөвлөмж өгсөн болно.

“Багануур” ХК нь төвийн бүсийн эрчим хүчний нүүрсний хэрэглээний 60%-ийг дангаараа хангадаг, нийгмийн өндөр хариуцлагатай компани учир САЙН ЗАСАГЛАЛ бүрдүүлж удирдлага, ажилтнууд зэрэг оролцогч талуудын хооронд хяналтын тэнцвэр бий болсон, мэдээ мэдээллийн урсгал тайлагнал тодорхой бөгөөд ил тод болсон, компанийн эрх мэдлийн түвшин бүрт хариуцлага тооцох тогтолцоотой, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын соёлтой, компанийн хэмжээнд ёс зүйн өндөр стандартуудын хэм хэмжээг тогтоосон байх нь нэн чухал бөгөөд үүний үр дүнд компанийн тэдийгүй хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, ажилтан, бэлтгэн нийлүүлэгч, хэрэглэгчийн тогтвортой хөгжил бий болох юм.

**Компанийн засаглалыг ахиц дэвшлийн хүснэгтээр үнэлсэн нэгтгэл**

| № | Компанийн засаглалын чиглэл | Зөвлөмж | Түвшин |
|---|---|---|---|
| 1 | Компанийн засаглалыг сайжруулах эрмэлзэл | 9 | 1, 2-р түвшин |
| 2 | ТУЗ-ийн гишүүдийн бүтэц, үйл ажиллагаа | 10 | 1, 2-р түвшин |
| 3 | Үйл ажиллагаа болон орчны хяналт | 4 | 1-р түвшин |
| 4 | Ил тод, нээлттэй байдал | 2 | 1-р түвшин |
| 5 | Жижиг хувьцаа эзэмшигчдэд хандах хандлага | 3 | 1, 2-р түвшин |
| 6 | Санхүүгийн сахилга бат | 4 | 1-р түвшинг хангаагүй |
| | НИЙТ | 32 | |



# ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

## КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



# БАЙГАЛЬ ОРЧИН, НӨХӨН СЭРГЭЭЛТ

"Багануур" ХК байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээхэд нийт 116.5 сая төгрөг төлөвлөснөөс 112.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

**Агаарын чанар:** Агаарын чанарт нөлөөлөгч бохирдуулагч бодис болох хүхрийн давхар исэл, азотын давхар ислийн шинжилгээг уурхай дээр 3 цэг, дүүрэгт 2 цэг сонгон Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори (БОХЗТЛ)-оор шинжилгээг 2 удаа хийлгэсэн. Агаарын бохирдол нь дулааны улиралд стандарт хэмжээнд (O2/0.45, NO2/0.200) боловч өвлийн улирлын хэмжилтээр SO2 хамгийн ихдээ 0.033мг/м$^3$ стандарт хэмжээнд, NO2 Уурхайн захиргааны хэсэг орчимд 0.531мг/м$^3$, уулын 1-р хэсэгт 0.333 мг/м$^3$ хүрч стандарт хэмжээнээс хэтэрсэн. Уул-2 хэсэгт болон дүүргийн 2 цэгт стандарт хэмжээнд байв. 2019 оны 2-р сард дахин давтан шинжилгээ хийхэд SO2 хамгийн ихдээ 0.045 мг/м$^3$, NO2 0.155 мг/м$^3$ стандарт хэмжээнд байна.

Агаарын тоосжилт 2 ба 3-р улирал (дулааны улирал)-д ихэнх хэмжилт стандарт хэмжээнд, 1 үзүүлэлт 0.264 мг.м$^3$ буюу стандарт хэмжээнээс хэтэрсэн байна. Харин 1 ба 4-р буюу өвлийн улиралд 2-оос бусад цэгт 0.116-0.281 мг/м$^3$ хүрч стандарт хэмжээнээс хэтэрсэн. Агаар дахь тоосжилтын бохирдлын хэтрэлтэд замын тоос хамгийн их нөлөөлж байна. Дулааны улиралд зам усалгааны ажил хийгддэг, өвөл усалгаа хийх боломжгүй байгаа нь тоосжилтод нөлөөлж байна.

2016 онд 47.1 мянган км замыг 73010 тн усаар усалж байсан бол 2017 онд замын тоосжилтыг бууруулахаар зам усалгааны 30 тн багтаамжтай HOWO170, 171 маркийн 2 машин худалдан авч ашиглалтад оруулснаар 2017 онд 53.6 мянган км замыг 115320 тн усаар, 2018 онд 72.9 мянган км замыг 196380 тн усаар усалсан. Нийт шүүрүүлсэн усны 0.97%-ийг тоос дарахад зарцуулсан. Мөн замын тоосжилтыг багасгахаар грейдер 14М техник худалдан авч, 2017 онд нийт 8.5 км зам хайргажуулж, 10.3 км түрж зассан бол 2018 онд 13.6 км зам хайргажуулж, 15.3 км замыг түрж тоосжилт ихсэхээс сэргийлсэн. 2018 онд замын тоосжилтын судалгааг "Грийн ази консултинг" ХХК-аар хийлгэсэн.

**Хөрсний бохирдол:** 2-р улиралд 13, 4-р улиралд 13, нийт 26 цэгээс хөрсний дээж авч БОХЗТЛ-иар хөрсний агрохими, хүнд металл, нефтийн үзүүлэлтийг шинжлүүлж байна. Эхний шинжилгээгээр ихэнх эмлемент хэвийн хэмжээнд гарсан бөгөөд Дулааны станц орчмын CO (кобальт) нь стандарт хэмжээнээс өндөр гарсан ч хортой агууламжийн хэмжээнд хүрээгүй, хэвийн хэмжээнд гарсан байна.

**Цацраг идэвхижил:** Цацрагийн хэмжилтийг БОХЗТЛ-иор хийлгэсэн. Хэмжилтээр агаар дахь цацрагийн агууламж 2017 онд хамгийн ихдээ 0.13 µЗв/цаг, хөрсөн дээр цацрагийн агууламж 0.15 µЗв/цаг буюу хэвийн хэмжээнд гарсан байна.


Нөхөн сэргээлт 190.5 га
(1999-2018 он)


31029 мод, бут
(2005-2018 он)


Багагүн нуурын нөхөн сэргээлт (2005 оноос)


- Булгийн эх хамгаалах
- Шувууны үүр байгуулах
- Хэрлэн голын эрэгт мод тарих
- Голын гольдрол сэргээх
- Хиймэл цөөрөм
- Хог хаягдал ангилан ялгалт







2018 онд 0.15 µЗв/цаг, хөрсөн дээр цацрагийн агууламж 0.21 µЗв/цаг буюу хэвийн хэмжээнд гарсан байна.

**Усны бохирдол:** Газрын доорхи болон гадаргын усанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний хувьд гадаргын усны шинжилгээг дулааны улиралд 2 удаа, гүний усны шинжилгээг 4 удаа улирал бүр шинжлүүлсэн. Гүний усны шинжилгээг харьцуулах стандарт байхгүй, гадаргын усны шинжилгээгээр Багагүн нуурын NO2 (нитритийн азот) стандарт хэмжээнээс өндөр гарсан байна. 1-р улирлын шинжилгээгээр нуурыг тэжээх коллекторын дээж гар байгаа хэсэгт стандарт хэмжээнд боловч нууранд цутгаж байгаа хэсгээс авсан дээжид стандартаас өндөр гарсан нь замдаа бохирдолд өртсөн байна. 2-р улиралд авсан шинжилгээгээр тухайн үзүүлэлт нь стандарт хэмжээнд, 3-р улиралд нуурын баруун талаас авсан дээжид NO2 стандарт хэмжээнээс өндөр гарчээ. Тухайн өдөр авсан Багагүн нуурын зүүн хэсэг болон тэжээх коллектороос гарч байгаа хэсгээс авсан дээж стандарт хэмжээнд, цутгаж байгаа хэсэгтээ стандартаас бага зэрэг ихэссэн байна. Багагүн нуурын усны зарим үзүүлэлт нь стандарт хэмжээнээс өндөр бохирдолтой, уурхайгаас цутгаж байгаа коллекторын усны шинжилгээтэй харьцуулахад зөрүүтэй гарсан. Нуурын ус оролт гаралтын сэлгээгүйн улмаас бохирдолд орсон байна гэж дүгнэсэн. Иймд 2018 онд нуурын усанд зэгс суулгахаар төлөвлөсөн боловч үг ажил хийгдээгүй, 2019 онд дахин төлөвлөсөн байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт

| № | Бүрэлдэхүүн хэсгүүд | Биелэлт хувь 2017 он | Биелэлт хувь 2018 он |
|---|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийн бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 81.8 | 90.6 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт | 92.7 | 97.2 |
| 3 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 84.8 | 91.4 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | - | - |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | - | - |
| 6 | Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | 87.5 | 90.6 |
| 7 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | 90.5 | 93.8 |
| 8 | Удирдлагын зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт | 88.8 | 92.3 |
| 9 | Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт | 87.2 | 93.3 |
| 10 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, үр дүнгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл | 91.1 | 90.5 |
| | Дундаж | 88.05 | 92.4 |

Байгаль орчны төлөвлөгөөний гүйцэтгэл

| № | Нөхөн сэргээлт | Үр дүнгийн үзүүлэлт | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Нийт | 2016 оны эцсээр | 2017 | 2018 |
| | Техникийн нөхөн сэргээлт | | | | |
| 1 | Шимт хөрс хуулах | 222.9 мян.м$^3$ | 121.3 мян.м$^3$ | 68.4 мян.м$^3$ | 33.2 мян.м$^3$ |
| 2 | Нөхөн дүүргэлт | 10993.7 мян.м$^3$ | 2074 мян.м$^3$ | 4200 мян.м$^3$ | 5783.8 мян.м$^3$ |
| 3 | Хэлбэржүүлэлт | 25 га | 11.6 га | 3.4 га | 10 га |
| 4 | Шимт хөрсөөр хучих | 30 га | 10 га | 10 га | 10 га |
| 5 | Тэгшилгээ | 30 га | 10 га | 10 га | 10 га |
| | Биологийн нөхөн сэргээлт | | | | |
| 6 | Ургамалжуулалт | 30 га | 10 га | 10 га | 10 га |
| 7 | Зүлэгжүүлэлт | 2696 м$^2$ | 2420 м$^2$ | 91 м$^2$ | 185 м$^2$ |
| 8 | Мод, бут тариалалт (толгой) | 7285 ш | 1078 ш | 2564 ш | 3643 ш |
| | Дүйцүүлэн хамгаалалт | | | | |
| 9 | Багагүн нуурыг хамгаалах, шүүрүүлэлтийн усаар тэжээх | 642.8 мян.м$^3$ | 270.6 мян.м$^3$ | 181.8 мян.м$^3$ | 203.7 мян.м$^3$ |

Мөн нуурыг загасжуулах талаар мэргэжилтнээс зөвлөгөө авсан. Нуурын хөлдөлтийн гүнийг 2014 онд тодорхойлж байсан тул дахин одоогийн байдлаар тодорхойлж, загас үржих боломжтой эсэх талаар судалгаа хийлгэх хэрэгтэй гэж зөвлөсөн.

**Дүйцүүлэн хамгаалах:** 2017 онд 5ш жижиг шувууны үүр хийж байрлуулсан бол 2018 онд идлэг шонхрын 2 үүр шинээр байрлуулсан байна. Мөн 2018 онд 2 булгийн эхийг хашиж хамгаалсан байна. Намрын тарилтаар Хэрлэн голын эрэгт 40 бургас тарьсан.

**Химийн бодисын хадгалалт:** Химийн бодисын эрсдлийн үнэлгээгээр онцгой хортой 1, хортой 37, бага хортой 14, нийт 60 төрлийн бодис бүртгэлтэй байгаагаас агуулах стандартын дагуу ангилан тус тусад нь шүүгээнд хийж, сорох хоолой бүхий зориулалтын өрөөнд хадгалан, хамгаалалтын хувцас өмсөж орж байна. Тэсрэх материалын агуулах нь дүүргээс 3.5 км-т орших стандартын дагуу баригдсан, 24 цагийн өндөржүүлсэн хамгаалалттай байна. Агуулахад аммоны нитрат, эмульс гэсэн 2 нэр төрлийн бодис хадгалагддаг бөгөөд 2018 оны байдлаар эмульс 36,438 кг хадгалаастай байна.

**Ургамалд үзүүлэх нөлөөлөл:** 2010, 2011 онуудад нөхөн сэргээсэн талбайд тус бүр 3 цэгээс ургамлын тооллого хийхэд ургамлан бүрхэц 2017 онд 67-81%-тай байсан бол 2018 онд 79-91%-тай болж өссөн. Нөхөн сэргээсэн талбайн ургамлан бүрхэцийн хэмжээ эрүүл талбайн ургамлан бүрхэцтэй харьцуулахад 2017 онд 77.9-94.2%-тай, 2018 онд 82.3-94.8%-тай байна.

**Амьтанд үзүүлэх нөлөөлөл:** Эдэлбэр талбай дахь тарвагатай талбайг технологийн автомашин явуулахгүйгээр хашиж хамгаалсан бөгөөд жил бүр тооллого хийх, дошны амсар дээр хужир тавьж өгөх, дошны байрлалзүйн зураг хийх зэрэг арга хэмжээ авч байна.

| № | Амьтны нэр | 2017 | 2018 |
|---|---|---|---|
| 1 | Тарвага | 9 | 2 |
| 2 | Үнэг | 3 | 3 |
| 3 | Туулай | 1 | 2 |
| 4 | Сар шувуу | - | 1 |
| 5 | Хүн | - | 2 |

**Нүүлгэн шилжүүлэлт:** Тус компани өөрийн эдэлбэр газарт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд дүүргийн иргэд, оршин суугчид суурин учраас нүүлгэн шилжүүлэлт хийх, нөхөн олговор олгох шаардлага байхгүй. Түүх соёлын өв хамгаалах тухайд, өнөөдрийн байдлаар соёлын өв илэрсэн тохиолдол бүртгэгдээгүй байна.

**Хог хаягдлын менежмент:** Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулахдаа хоолны газар, контор, ахуйн үйлчилгээний комбинат, үйлдвэрийн цех хэсгүүдээс үйлвэрлэлийн болон ахуйн хатуу, шингэн хог хаягдал гардаг. Эдгээр хог хаягдлын ихэнх нь энгийн хог хаягдал бөгөөд эргэн ашиглагдах хог хаягдлууд ч байна. Долоо хоног бүр хэсгүүд орчиндоо, улирал бүр бүх нийтийн цэвэрлэгээ, хээрийн цэвэрлэгээгээр дүүргийн хүр хогийн цэг, Хэрлэн гол, Талын толгойн хойд Нарийн гол ормыг цэвэрлэсэн.

**Бусад:** Уурхайгаас дүүрэг хүрэх зам дагуу мал ордог хэсгүүдийг хааж тор татсан. 2 дахь түүхий эдийн тос агуулах хэсэг болон захиргааны ШТС-ын шатахуун түгээгүүрийн хэсгийг хатуу хучилттай болгож зассан.

| № | Ангилал | | 2017 он | 2018 он | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ахуйн хог хаягдлын хэмжээ | | 182.5 тн | 116.5 тн | |
| 2 | Үйлдвэрийн хог хаягдал | | | | |
| | | Тос масло | 131,828 | 25118 | |
| | | Маслын шүүр | 10 | 25 | |
| | | Ламп | 4,273 | 4312 | |
| | | Аккумлятор | - | 35 | |
| 3 | Дахин ашиглагдах хог хаягдал | | Тооцоогүй | | Тооцсон. 21 төрлийн хог хаядлыг дахин ашигласан |










Байгаль орчны хамгаалалт, нөхөн сэргээлтийн шалгуур үзүүлэлтүүд

| № | Зорилт | Гүйцэтгэл | Үр дүнгийн үзүүлэлт | | | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2017 төл | 2017 гүйц | 2018 төл | 2018 гүйц | |
| 1 | **Нөхөн сэргээлт** | 2018 он хүртэл 190.5 га талбайд нөхөн сэргээлт хийгээд байна | 119.6 сая | 99.1 сая | 116.5 сая | 112.8 сая | |
| 2 | Эвдэрсэн талбайн хэмжээ | 2017 оны сүүлийн байдлаар олборлолтод өртсөн нийт 1261.8 га талбай байна | өмнөх онд нийт эвдэрсэн 1234.1 га | нэмж эвдэрсэн 27.7 га | өмнөх оны эвдэрсэн талбай 1261.8 га | нэмж эвдэрсэн 33 га | |
| 3 | Шимт хөрсний хэмжээ | 5 агуулахад 623.5 мян.м3 шимт хөрс байна | 158.9 мян.м3 | 68.4 мян.м3 | 117 мян.м3 | 33.2 мян.м3 | |
| 4 | Нөхөн дүүргэлт | Дотоод овоолгод автоор нөхөн дүүргэлт хийж байна | 5870 мян.м3 | 4200 мян.м3 | 4780 мян.м3 | 5783.8 мян.м3 | |
| 5 | Шимт хөрс хучсан талбайд 4 м өргөнтэй берм байгуулж, үерийн далан хийх | | | | | | Нөхөн сэргээж байгаа талбай нь берм байгуулах шаардлагагүй талбай байсан |
| 6 | Олон наст бүрхэвч ургамал тариалах | Олон наст (ерхөг, согоовор, царгас, өлөнгө) ургамлаар тариалалт хийсэн | 10 га | 10 га | 10 га | 10 га | |
| 7 | Нөхөн сэргээсэн талбайд 3 хяналтын цэг байгуулж, ургамлын тооллого хийж бүртгэл хөтөлнө | 2010, 2011 оны талбайнуудад 3 цэгт хяналтын тооллогыг 2017 онд хийн, 2018 дахин хийж харьцуулалт хийсэн. Ургалтын хувь нэмэгдсэн байсан | 2010 оны талбайд 3, 2011 оны талбайд 3, эрүүл талбайд 3, нийт 9 цэгт тоолно | нийт 9 цэгт тооллого хийсэн | 2012 оны талбайд 3, 2011 оны талбайд 3, эрүүл талбайд 3, нийт 9 цэгт тоолно | нийт 9 цэгт тооллого хийсэн | |
| 8 | **Цэцэрлэгжүүлэлт** | | | | | | |
| 9 | Мод бут | Шинээр мод бут тарьж, усалгаа арчилгааг тогтмол хийж байна | 2500 ш | 2564 ш | 4300 ш | 3643 ш | Дугуйн зам дагуу уурхайгаас дүүрэг хүртэл 3750 мод төлөвлөсөн. Гэтэл цахилгаан шугам, шилэн кабелиас шалтгаалан дүүрэг хүртэл хийх боломжгүй болж, 2940 мод бут тарьсан. Хэрлэн голын эрэгт 40 ш бургас тарьсан |
| 10 | Цэцэгжүүлэлт | Цэцэгжүүлэх талбайн үрсэлгээг өөрсдөө үрслүүлж байна. 2017 онд 1000 ш үрсэлгээ гаргаж байсан бол 2018 онд 5000 ш цэцгийн үрсэлгээ гаргасан | 66 м2 | 66м2 | 66 м2 | 185 м2 | Цэцгийн үрсэлгээ бойжуулахад зориулж 2 ш хүлэмж 36 ш үрсэлгээний хайрцаг, 32 ш цэцгийн сав шинээр нэмж хийсэн. Мөн гацуур тарих 17 ш модон бортого хийж байрлуулсан |
| 11 | Зүлэгжүүлэлт | Захиргаа орчмын талбайд зүлэгжүүлэлт хийсэн | | 91м2 | | 120м2 | |
| 12 | Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа | 2017 онд хийлгэн хүлээн авсан | 45 сая | 44.5 сая | | | |
| 13 | Замын тоосжилтыг дарах | 2017 онд шинээр 2 усны машин, 1 ш грейдер нэмж авсан | | 5364 км зам усалж, 10300 м замд түрэлт засвар хийсэн | | 72938 км зам усалсан. 15300 м замд түрэлт засвар хийсэн | Зам засалт, зам усалгааны ажил нэмэгдсэн |
| 14 | Багагүн нуурын судалгааны ажил хийж загас үржүүлэх ажлыг эхлүүлэх | Загасжуулахад судалгаа хийлгэх шаардлагатай. Загас амьдрах боломжтой эсэх талаар нуурын судалгаа хийлгэхээр 2018 онд төлөвлөсөн | Загасжуулах | хийгдээгүй | судалгаа | Нуурын хөлдөлтийн гүнийг одоогийн байдлаар дахин тодорхойлох | Хөлдөлтийн гүнийг тодорхойлсны дараа судалгааны ажил хийлгэх шаардлагатай гэсэн зөвлөмж өгсөн |

# ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

2017 оноос "Багануур" ХК нь ХАБЭА-н удирдлагын тогтолцоог шинэчлэн боловсронгуй болгох зорилгоор "Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо" MNS-OHSAS 18001:2012 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хөдөлмөрийн нөхцөлийн хэмжилт, эрүүл ахуйн үзлэг хяналтын үр дүнг ашиглан ажлын нөхцөл хангалтгүй байсан ажлын байрны жагсаалт гарган ТБХ-т өгч, ажлын байрны нөхцөл сайжруулах нэгдсэн төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг хянан, хэсгийн удирдлага болон холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажилласнаар 38 ажлын байрны нөхцөл сайжирсан.

ХАБЭА-н сарын аяны хүрээнд ажлын байрны нөхцөл 5С-ийг сайжруулах болзолт уралдааныг бүх хэсгийн дунд зарлаж, 7 хэсгийн 11 ажлын байр оролцсон. Хэсэг нэгжүүдийн ажлын байрны 5С эмх цэгц тохижилтыг улирал бүр үзлэг хийж программд оруулан, зөрчилтэй байгаа ажлын байрны талаар улирал бүрт хэсгийн удирдлагад үүрэг даалгавар өгч ажиллалаа.

- ХАБЭА-н удирдлагын тогтолцоог үе шаттай хэрэгжүүлж эхэлсэн.
- ХЭМАБ-ын бодлого, 3 жилийн хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулсан.
- Стандартын дагуу ХАБЭА-н бичиг баримт, хэлтсийн бүтцэд өөрчлөлт орсон, орон тоо нэмэгдсэн.
- ХАБЭА-н сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг эрх зүйн шаардлагын дагуу боловсруулсан.
- 2018 онд компанийн хэмжээнд үйлдвэрлэлийн осол 1, осолд дөхсөн тохиолдол 1 бүртгэгдсэн байна.
- Хөнгөн гэмтлийн тоо өмнөх оноос буурсан.













ХАБАЭ-ийн шалгуур үзүүлэлт

| № | Шалгуур үзүүлэлт | 2017 | 2018 |
|---|---|---|---|
| 1 | Осол авааргүй ажилласан өдөр, тоо | 365 | 312 |
| 2 | Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, тоо | 0 | 1 |
| 3 | Осолд дөхсөн тохиолдол, тоо | 1 | 2 |
| 4 | Хөнгөн гэмтэл, тоо | 15 | 7 |
| 5 | Техник ашиглалтын зөрчил, тоо | 0 | 1 |
| 6 | Техникийн осол, тоо | 1 | 0 |
| 7 | Ээлжит үзлэгээр илэрсэн зөрчил, тоо | 257 | 158 |
| 8 | Ээлжит үзлэгээр илэрсэн зөрчлийн арилгалт, хувь | 96% | 97% |
| 9 | Ээлжит бус үзлэгээр илэрсэн зөрчил, тоо | 182 | 135 |
| 10 | Ээлжит бус үзлэгээр илэрсэн зөрчлийн арилгалт, хувь | 100% | 100% |
| 11 | Хөдөлмөрийн чадвар түр алдалт, хүн/цаг | 683 | 714 |
| 12 | Ажилтнуудаас ирүүлсэн зөрчлийн мэдээлэл, тоо | 368 | 537 |
| 13 | Ажилтнуудын илрүүлсэн аюулын арилгалт, хувь | 97% | 98% |
